



ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

ХӨТӨЛБӨРИЙН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ

Байгууллагын нэр: ИХ ЗАСАГ ОЛОН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Хөтөлбөрийн нэр: “ЭРХ ЗҮЙ” МАГИСТРЫН СУРГАЛТ

Индекс: E04210101

Шинжээчийн баг:

Ахлагч: Ж.Мөнхболд

Гишүүд: Ш.Цогтоо

Ж.Ганболд

Улаанбаатар хот

2020 он

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар

- I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**
- II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**
- III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**
 - Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт
 - Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа
 - Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл
 - Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт
 - Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа
 - Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа
 - Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт
- IV. Уулзалтад оролцогчдын нэрс**
 - i. Багш ажилтны төлөөлөл
 - ii. Суралцагчдын төлөөлөл
 - iii. Ажил олгогчдын төлөөлөл
 - iv. Төгсөгчдийн төлөөлөл
- V. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**
- VI. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АНУ	Америкийн нэгдсэн улс
АГҮБ	Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний баг
БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
БЗД	Баянзүрх дүүрэг
БШУЯ	Боловсрол, Шинжлэх ухааны яам
БНСУ	Бүгд найрамдах Солонгос улс
ИЗОУИС	Их Засаг олон улсын их сургууль
МОХ	Монголын оюутны холбоо
МХХ	Монголын хуульчдын холбоо
МУИС	Монгол Улсын их сургууль
МВ	Мегабайт
ОХУ	Оросын холбооны улс
ОУИС	Олон улсын их сургууль
ОУЭШБХ	Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал
ХИС	Хүмүүнлэгийн ухааны их сургууль
ХБНГУ	Холбооны бүгд найрамдах герман улс
УЗ	Удирдах зөвлөл
ШУС	Шинжлэх ухааны сургууль
ЭШХ	Эрдэм шинжилгээний хурал

I. ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮЙЛ ЯВЦ, ТӨЛӨВЛӨЛТ

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Их засаг олон улсын их сургууль Ikh zasag international University		
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Эрх зүй Law		
Индекс	E04210101		
Шинжээчид	1. Ж.Мөнхболд /Дотоод хэргийн их сургуулийн Ахисан шатны боловсролын сургуулийн захирал/ 2. Ш.Цогтоо /Үндсэн хуулийн цэцийн гишүүн, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн зөвлөх профессор/ 3. Ж.Ганболд /Legal Protection хуулийн фирмийн гүйцэтгэх захирал/		
БМИҮЗ-ийн зохицуулагч	П. Оргилмаа /БМИҮЗ-ийн Ажлын албаны магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн/		
Төлөвлөгөө, хэрэгжилт	Огноо	Хийгдсэн байх ажлууд	
	2020 оны 05 сарын 28	1. Шинжээчийн баг 09:00 цагт ИЗОУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн удирдлага, өөрийн үнэлгээний багтай уулзалт хийсэн. Шинжээч ажиллах хуваарь, хөндлөнгийн үнэлгээний талаар танилцуулав. Хөтөлбөрийн танилцуулгыг ШУС-ийн захирал Ш.Наранбаатар танилцуулав. 2. Хөтөлбөрт хамаарах материаллаг бааз /номын сан, лаборатори, төвүүд/-тай танилцсан. 3. Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой танилцаж нэмэлт тодруулга авсан. 4. Өөрийн үнэлгээний багийнхантай уулзалт хийсэн. 5. Хөтөлбөрт хамаарах багш, ажилтнуудтай уулзалт хийж 18:00 цаг хүртэл ажиллав.	
	2020 оны 05 сарын 29	1.Шинжээчдийн баг өглөө 09:00 цагт цуглан дотоод ажлаа төлөвлөн, нотлох баримтуудтай танилцан, нэмэлт тодруулга авсан. 2.Магистрантуудтай уулзалт хийсэн /цахим/ 3.Төгсөгчдийн төлөөлөлтэй цахим уулзалт хийсэн. 4.Ажил олгогчдын төлөөлөлтэй цахим уулзалт хийсэн 5.Нотлох баримтуудтай танилцан, тодруулга авсан. 6.Шинжээчид үнэлгээний дүгнэлтээ нэгтгэж, өөрийн үнэлгээний багийнханд товч танилцуулав.	
	Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 08 дугаар тогтоолоор батлагдсан “Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам, дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагын дагуу ажиллав.	

II. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

Их Засаг ОУИС нь ахисан түвшний сургалтыг 1999 оноос явуулж эхэлсэн бөгөөд 2008 онд Эрдмийн сургууль болж, улмаар 2018-2019 оны хичээлийн жилээс Их Засаг ОУИС-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/02 тоот тогтоолоор Шинжлэх ухааны сургууль болон өргөжиж үйл ажиллагаагаа 21 дэх жилдээ амжилттай явуулж байна.

Тус сургуулийн эрх зүйн магистрын хөтөлбөр (E04210101)-ийг Монгол Улсын “Боловсролын тухай хууль”, “Дээд боловсролын тухай хууль”, Багшийн хөгжлийн тухай хууль” болон БСШУ-ны сайдын баталсан 2014 оны 09-р сарын 12-ны өдрийн А/370 дугаар тушаалаар батлагдсан “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам, “Их засаг ОУИС-ийн дүрэм” болон “Магистрын сургалт эрхлэх журам” зэрэг холбогдох хууль тогтоомж, боловсролын агуулга чиг хандлага, шаардлагад нийцүүлэн боловсруулсан.

Их Засаг олон улсын их сургуулийн Эрхэм зорилго:

“Их Засаг ОУИС мэдлэгийг үйлдвэрлэгч, баялаг бүтээгчдийг төрүүлэх, оюутан суралцагчдын ажил амьдралын баталгааг хангахад чиглэгдсэн сургалт, судалгаа, инновацийн бүтээлч чадамжтай, судалгааны их сургууль байна”.

Их Засаг олон улсын их сургуулийн Алсын хараа:

“ИЗОУИС нь инноваци, технологийн үсрэнгүй хөгжлийн үлгэр загвар болсон үндэсний түүх соёлын тэргүүлэх, орчин үеийн даяарчлагдсан их сургууль байна”.

Инноваци, нано технологийг хөгжүүлсэн орчин үеийн их сургуулийн хувьд Их Засаг ОУИС нь улс үндэстнийхээ нийтлэг эрх ашиг сонирхлын төлөө нийгэмд эерэг өөрчлөлтүүдийг бүтээх зарчмыг баримталсан нийгмийн хариуцлагатай их сургууль байна. Их Засаг ОУИС нь сургалт хүмүүжил, эрдэм шинжилгээ, судалгааны ажлынхаа олон улсын ач холбогдлыг бататгахын тулд гадаад, дотоодын байгууллагуудтай хамтран ажиллаж, дэлхийн хэмжээний сургуулийн шаардлагыг хангаж ёс зүйн зарчмыг ямагт баримталж ажиллана.

Шинжлэх ухааны сургуулийн эрхэм зорилго:

“Олон улсын болон үндэсний эрэлт хэрэгцээнд нийцсэн ахисан түвшний сургалт явуулж, эрдэм, шинжилгээ судалгааны ажлын өндөр ур чадвартай, зах зээлд хөрвөх чадамжтай, бүтээлч сэтгэлгээтэй мэргэжилтэн бэлтгэнэ”.

Эрх зүйн магистрын хөтөлбөрийн зорилго:

“Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, нийтлэг жишигт нийцүүлсэн сургалтыг зохион байгуулж, бакалаврын зэрэгтэй эрх зүйч мэргэжилтэнд эрдэм, шинжилгээ судалгааны ажлын арга зүй, ур чадварыг эзэмшүүлэхэд чиглэгдэнэ”.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэслэл нь “Монгол Улсын болон ОУ-ын эрх зүйн шинэтгэлийг хурдасгах, улам боловсронгуй болгох нь нийгмийн амьдралд нэн шаардлагатай байгаа энэ үед эрх зүйч мэргэжилтэй судлаач нарыг бэлтгэн гаргах явдал юм” гэж үзжээ.

III. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1 Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Тус сургуулийн эрх зүйн магистрын хөтөлбөрийг Монгол Улсын “Боловсролын тухай хууль”, “Дээд боловсролын тухай хууль”, Багшийн хөгжлийн тухай хууль” болон БСШУ-ны сайдын баталсан 2014 оны 09-р сарын 12-ны өдрийн А/370 дугаар тушаалаар батлагдсан “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам, “Их засаг ОУИС-ийн дүрэм” болон “Магистрын сургалт эрхлэх журам” зэрэг холбогдох хууль тогтоомж, боловсролын агуулга чиг хандлага, шаардлагад нийцүүлэн боловсруулж, батлуулан мөрдөн ажиллаж байна.
- Эрх зүйн магистрын (E04210101) хөтөлбөрийг боловсронгуй болгоход байнга анхааран ажиллаж, ИЗОУИС-ийн Ректорын тушаалаар батлагдсан хөтөлбөрийн дэд хороо нь нийт 8 удаа хуралдаж 6 удаа (2006, 2007, 2012, 2014, 2018, 2019 онуудад) сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөртөө нэмэлт өөрчлөлт оруулан, орчин үеийн нийгмийн шаардлага, суралцагч болон ажил олгогчдын хэрэгцээ зэргийг үндэслэн “Мэдээллийн технологид суурилсан судалгааны арга зүй”, хичээлийг шинээр оруулдаг болсон байна.
- Сургалтын хөтөлбөрийг сайжруулах, шинэчлэх чиглэлээр төгсөгч болон ажил олгогчдын төлөөллөөс жилдээ 2 удаа судалгаа авч, үр дүнг боловсруулан нэгтгээд, санал зөвлөмжөө хөтөлбөрийн хорооны хуралд хэлэлцүүлэн ажилладаг байна. Үүний үр дүнд эрх зүйн магистрын сургалтын журам, сургалтын төлөвлөгөөгөө шинэчлэн боловсруулж Эрдмийн зөвлөлийн 2019.12.11-ний хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж энэ хичээлийн жилээс мөрдөн ажиллажээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/ Туршлага:

- Нийгмийн шаардлага, ажил олгогч, төгсөгч, суралцагчийн эрэлт хэрэгцээ өөрчлөгдөх, орчин үеийн судлаачдад тавигдах шаардлага, ур чадвар, чиг хандлага нарийсах зэргийг оновчтой олж харан, сэтгэл ханамжийн судалгаа болон фокус ярилцлагын гэх мэт аргуудаар судалгаа авч хөтөлбөрөө байнга шинэчлэн сайжруулдаг.
- Тус хөтөлбөрийг орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх, эрх зүйч судлаачдын дутагдаж буй ур чадварыг хөгжүүлэх, төгсөгчдийнхөө мэдлэг, ур чадвар, хандлагад бодитой өөрчлөлт оруулахуйц зарим нэг хичээлийг сургалтын төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлсэн.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Эрх зүйн магистрын суогалтын хөтөлбөр нь зорилгодоо бүрэн нийцэж байна. Эрх зүйн магистрын хөтөлбөр (E04210101)-ийн зорилгоо Их Засаг ОУИС, ШУС-ийн эрхэм зорилго, Их Засаг ОУИС-ийн алсын хараа, бодлогын баримт бичгүүдийг удирдлага болгон боловсруулан тодорхойлж 2019 онд шинэчлэн батлуулсан байна.
- Сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, сайжруулах ажлыг байнга хийхээс гадна хөтөлбөрт сонирхогч болон оролцогч талуудын санал, хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлагыг тусган хэрэгжүүлдэг нь хөтөлбөрийн хороо, дэд хорооны хурлын тэмдэглэл, талуудаас авсан судалгааны материал, түүний үр дүнд хийсэн анализ, түүнийг хөтөлбөрт тусгасан байдал зэргээр нотлогдож байна.
- Хөтөлбөрт оруулсан өөрчлөлт шинэчлэлийн талаар тухай бүр нь ИЗОУИС-ийн болон ШУС-ийн вэбсайт, пейж хуудас, нүүр номын бүлгүүд, номын сан гэх мэт сувгуудаар олон нийтэд нээлттэй ил тод мэдээлжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/ Туршлага:

- “Мэдээллийн технологид суурилсан судалгааны арга зүй” хичээлийг хөтөлбөрт тусгасан нь судлаач бэлтгэх хөтөлбөрийн зорилгыг биелүүлэхэд хувь нэмрээ оруулж байна. Мөн “Монголын төр эрх зүйн түүхийн судлал” хичээлийг нэмж өгсөн нь ИЗОУИС-ийн өөрийн онцлог давуу тал болохоос гадна сургуулийнхаа эрхэм зорилгод нийцэж байна.

Зөвлөмж:

-Хөтөлбөрийн өнөөгийн хүрсэн түвшин, чанар, ололт амжилтыг бууруулалгүйгээр тасралтгүй хөгжихөд анхаарах

1.3 Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын

үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Эрх зүйн магистрын (E04210101) хөтөлбөрийг нийт 6 удаа 2006, 2007, 2012, 2014, 2018, 2019 онуудад хэлэлцэн сайжруулж, шинэчилэн боловсруулсан нь хөтөлбөрийн дэд хорооны болон ИЗОУИС-ийн Эрдмийн зөвлөлийн хуралдааны тэмдэглэлүүдээр нотлогдож байна.
- Их Засаг ОУИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2019.12.11-ний хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан нэгж хичээл бүрийн хөтөлбөрийг шинэчлэн, батлагдсан загварын дагуу боловсруулж хөтөлбөрийн дэд хорооны хурлуудаар нэг бүрчлэн хэлэлцэж үзээд Их Засаг ОУИС-ийн Ректороор батлуулан өдөр тутмын сургалтын үйл ажиллагаандаа хэрэглэж байна.
- Нэгж хичээл бүрийн хөтөлбөрт тухайн хичээлээр олж авах мэдлэг, чадвар, хандлагаас гадна суралцагчийн хүрэх үр дүн, дүгнэх аргачлалыг тодорхой зааж өгсөн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/ Туршлага:

- Цахим хичээлийг видео, аудио хэлбэрүүдээр үр дүнтэй зохион байгуулж сургалтын нэглсэн програмыг ашиглаж байна.
- Хичээл нэг бүрээр E-content бэлтгэн сургалтад ашигладаг.
- Сургалтын төлөвлөлтийн баримт бичгүүдийн хадгалалт, хамгаалалт, архивлах ажиллагаа сайн.

Зөвлөмж:

- Төгсөгчдийнхөө давтан сургалтад хамруулах ажлыг тогтмолжуулахад анхаарах
1-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: **БҮРЭН ХАНГАСАН**

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- ИЗОУИС-д мөрдөгдөж буй эрх зүйн акт, баримт бичгүүдэд хяналт шинжилгээ хийгдэж 2017 оны хичээлийн жилд шинэчилсэн найруулгаараа 4 дэх удаагаа хэвлэгдэж, хөтөлбөрт оролцогчдын гарт хүрсэн байна. Ингэснээр сургалт, эрдэм

шинжилгээ, хүмүүжлийн ажлыг дээд боловсролын чанар стандартад нийцүүлэн явуулах эрх зүйн орчин бүрэн бүрдсэн гэж үзлээ.

- Магистрын сургалтын хөтөлбөрийн онцлог нь онол, дадлагын /бие даан судлах/ хичээлийн зохистой харьцааг /1:1/ бүрдүүлэх, хичээлийн чанарыг сайжруулах, багш-суралцагчдын уялдаа холбоо, сургалтын орчныг сайжруулж, сургалтын онол, практикийг хослуулах, харьцуулсан эрх зүй, олон улсын эрх зүйн шинэ хандлагыг цаг алдалгүй тусгаж байх бодлогыг барьж ажилладаг нь сургууль дээр очиж ажиллах болон төгсөгч нартай ярилцах үед илэрч байсан.
- Судалгааны ажлыг эрчимжүүлэх, суралцагчдын судалгааны ажлыг чиглүүлэх, судалгааны арга барил эзэмшихэд нь туслах, магистрант бүрийг эрдэм шинжилгээний ажил хийлгэх зорилгоор эрдэм шинжилгээний семинарийг тогтмол зохион явуулдаг нь тэдний ажлын төлөвлөгөө тайлан, ЭШХ-уудын эмхэтгэл зэргээр нотлогдож байна.
- Сургалтын төлөвлөгөөний өөрчлөлтийг эрдэм шинжилгээ, инноваци эрхэлсэн проректороор ахлуулсан баг ажиллаж судалгаа хийсний үндсэн дээр төлөвлөгөөний зохистой харьцаа болон хичээлийн хоорондын уялдааг тооцон нийт 6 удаа 2006, 2007, 2012, 2014, 2018, 2019 онуудад хэлэлцэн сайжруулж, шинэчлэн боловсруулсан.
- Тус хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага нь хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцэж байгаа нь хөтөлбөрт тусгагдсан хичээл хоорондын залгамж холбоо, нийцлийг хангах зорилгоор сургалтын төлөвлөгөөг судалгаанд үндэслэн сайжруулан шинэчилсний үр дүн нь гарсан байна.
- Магистрантуудыг аль болох судалгааны магистраар төгсөхөд нь дэмжлэг үзүүлэн, шинжлэх ухааны судалгааны арга зүй, мэдээллийн технологид суурилсан судалгааны арга зүй хичээлүүд дээр суурилуулан бие даалт, судалгааны ажлыг гүйцэтгэхүйц байдлаар зохион байгуулж байгаа нь оновчтой байлаа.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/ Туршлага:

- Аль ч эрх зүйн чиглэлээр судалгааны ажил хийж тайлан бичихдээ нэгдүгээр бүлэгт нь заавал түүхэн уламжлалын асуудлыг судлан бичиж байгаа нь ИЗОУИС-ийн өөрийн өвөрмөц онцлог юм. Ингэснээр суралцагчдын асуудлын мөн чанарт ул суурьтай хандах, асуудлыг түүхчлэн судлах арга барил нь илүү хөгжиж байгаа нь судалгааны ажлуудын сэдэв, бичвэр зэргээс тодорхой болж байсан. Сургуулийнхаа эрхэм зорилгод ч нийцэж байна.

Анхаарах асуудал:

- Ижил төстэй хөтөлбөр хэрэгжүүлдэг гадаад, дотоодын их сургуулиудын хөтөлбөрөөс шинэлэг болон тэргүүн туршлагыг судлан хэрэгжүүлэх
- Зарим нэг хичээлийн агуулгыг тулгамдсан асуудал болгон, асуудлыг шийдвэрлэх байдлаар зохион байгуулах

Зөвлөмж:

- Гадаад дотоодын ижил төстөй байгууллага, хөтөлбөртэй хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх арга боломжийг судлан, хэрэгжүүлэх

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлүүдийн шинэчлэн батлуулсан хөтөлбөрүүд
- ИЗОУИС-ийн төгсөлтийн шалгалтын журам
- Эрх зүйн магистрын сургалтыг зохион байгуулах журам
- Магистрантуудаас мэргэжлийн болон англи хэлний нэгдсэн шалгалт авах журам, түүний хэрэгжилт
- Их семинар зохион байгуулах журам, түүний хэрэгжилт, тайлан мэдээ
- Суралцагчдын сэтгэл ханамжийн судалгаа сүүлийн 5 жилээр, түүний үр дүнг хэрэгжүүлсэн байдал
- Багшийн талаар авсан судалгаа сүүлийн 5 жилээр, түүний үр дүнг хэрэгжүүлсэн байдал
- Багшаас авсан сэтгэл ханамжийн судалгаа сүүлийн 3 жилээр, түүний үр дүнг хэрэгжүүлсэн байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/ Туршлага:**

- Судалгааны арга зүйд суурилсан, хичээл бүрийн залгамж холбоог хангасан, нэг нь нөгөөгөө үл нөхөх нөхцөлтэй бие даалт өгч хийлгэж байна.
- Салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн, шилдэг тэргүүний эрдэмтэн багш нарыг урьж авчран лекц уншуулдаг нь онол практик хосолсон “амьд” сургалт болж байна.
- Суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх үнэлгээний арга хэлбэр, хүрэх үр дүн, агуулгын хамаарлыг тогтоож хичээл бүрийн хөтөлбөрт тодорхой тусгаж өгсөн.
- Хөтөлбөр хэрэгжүүлж буй багш нар нь идэвхтэй сургалтын аргуудыг хэрэглэж, арга зүйг нэвтрүүлсэн.
- Сургалтыг идэвхтэй аргаар зохион байгуулахад шаардлагатай бүхий л орчин, урамшууллын тогтолцоо, материаллаг бааз бүрдсэн.

Анхаарах асуудал:

- Зайнаас суралцах боломж, нөхцөл, давуу сул талаа бодитой олж харах

Зөвлөмж:

- Асуудал шийдвэрлүүлэх арга зүйд тулгуурлан хичээлийг зохион байгуулах

- Эрдэмтэн багш нарыг урин зөвхөн лекц уншуулаад зогсохгүй тэдэнтэй чөлөөт ярилцлага өрнүүлэх, судалгааны ажлын дадлага туршлагаас нь хуваалцсан төрөл бүрийн ажил зохион байгуулах

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутнуудаас шалгалт авахдаа зөвхөн тестээр хязгаарлахгүйгээр эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавиулах, судалгааны ажил бичүүлэх, эсээ бичүүлэх, ярилцлага хийх зэрэг аргыг хослон хэрэглэдэг нь тухайн суралцагч зөвхөн сонсогч биш мэдлэг эзэмшигч болоход нь түлхэц болдог.
- Их Засаг ОУИС-ийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцэн баталсан Магистрын сургалт явуулах журамд суралцагчийн үнэлгээний асуудлыг тодорхой тусгасан байна.
- Мөн лекц семинарын хичээл явуулах болон оюутны мэдлэг чадварыг дүгнэх заавар, Шалгалтын явцыг хянах, дүгнэх журам, Шалгалтын үнэлгээтэй холбоотой асуудлыг барагдуулах журам, шалгалтаас хоцорсон суралцагчийн асуудлыг шийдвэрлэх журам зэрэг заавар, журмуудад суралцагчийн үнэлгээний асуудлыг тусгасан байна.
- Хичээлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэхдээ дараах арга, хэлбэрийг ашиглаж байна. Үүнд:
- Монгол Улсын Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм журмууд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/370 дугаар тушаалаар батлагдсан магистр, докторын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага, БШУ-ны сайдын 2014.09.12-ны “Мэргэжлийн чиглэл индекс шинэчлэн батлах тухай” А/370-гоот тушаал, ИЗОУИС-ийн дүрэм, Магистрын сургалтын журам болон бусад дүрэм журмыг мөрдүүлж байна.
- Хичээл бүрээр тестийн сан бүрдүүлэн суралцагчдын онолын мэдлэгийн түвшинг тогтооход хэрэглэж байна.
- Үнэлгээний рубрикийн арга, когнитивийн түвшинг үнэлэх арга, эффективийн түвшинг үнэлэх арга, психомоторын түвшинг үнэлэх арга зэрэг аргуудыг хэрэглэдэг.
- Үнэлгээ нь суралцах үйл явцыг дэмжсэн, бодитой, үнэлгээний нийтлэг жишигтэй харьцуулах боломжтой байна.
- Хөтөлбөрийн явцад суралцагчийн бие даан суралцах үйл ажиллагааг дэмжих, хөгжүүлэх багшийн зөвлөн туслах, чиглүүлэх, хамтран ажиллах зарчмыг үзэл баримтлал болгож суралцагчийг үнэлэх тогтолцоог бүрдүүлэх зорилгоор суралцагчийн мэдлэг чадвар, хандлагыг үнэлэх үйл ажиллагаандаа шинжлэх ухааны үндэстэй, бодитой, шударга, ил тод байх зарчмыг удирдлага болгон ажиллаж, сургалтын үйл ажиллагааны эрх зүйн баримт бичгүүдэд тусган ажиллаж байгаа нь дүрэм журмууд болон хичээлийн хөтөлбөрөөр нотлогдож байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/ Туршлага:

- Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл нэг бүрийн үнэлгээний арга, хэлбэр нь суралцагчдыг тасралтгүй хөгжихөд хөтөлж байдаг нь хичээл бүрээр олгох суралцахуйн үр дүнгээр тодорхой болж байна.

Зөвлөмж:

- Суралцагчид өөрөө өөрсдийгөө үнэлэх арга замыг судлан боловсруулах

2-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагаи хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- ШУС-ийн хичээлийн байр нь 2000 онд ашиглалтанд орсон, 1138 ам метр талбайтай, нэг ээлжиндээ 610 оюутан зэрэг хичээллэх хүчин чадалтай, тус сургуулийн өөрийн байр бөгөөд нэг суралцагчид оногдох талбайн хэмжээ нь 3.4 м.кв байгаа нь улсын стандарттай харьцуулахад даруй 2.5 дахин илүү үзүүлэлт юм. Энэ нь Боловсролын тухай хуульд заасан боловсролын байгууллагын сургалтын орчны хэм хэмжээнд нийцсэн байна.
- Хичээлийн байрны давхар бүрт галын аюулгүй ажиллагааны схем, галын шланг ба галын хор, ослын үед хэрэглэх бүрэн чөлөөлөгдсөн гарцуудтай, гамшгийн үеийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй, /сургуулилт хийдэг/, цахилгааны газардуулгын ажил бүрэн хийгдсэн.
- Сүүлийн 5 жилд сургалтын орчинг улам сайжруулах зорилгоор нийт 22 объектыг шинээр байгуулах болон шинэчлэн засварлажээ. Тухайлбал: лабораторуудын урсгал засвар, эрдэм шинжилгээ судалгааны ажлын танхим, давхар бүрийн ариун цэврийн өрөөнүүдийн засвар, тохижилт, багш нарын амралтын өрөө, суралцагчдын чөлөөт цагийн өрөө, цайны булан, номын сангийн уншлагын хэсэг, багшийн хөгжлийн төв гэх мэт
- Хичээл сургалтын бүх анги танхимуудад ухаалаг дэлгэц, индэр, проектор, телевизор зэргийг бүрэн байрлуулсан байна.
- Багшийн хөгжлийн төв нь өндөр хүчин чадал бүхий судалгааны програмууд суулгасан, 24МВ хурдтай, нээлттэй эх сурвалжуудыг ашиглах бүрэн боломжтой 20 компьютертэй байна.

- Багш суралцагчдын эрүүл мэнд, чөлөөт цагийг зохистой өнгөрүүлэх зорилготой амралтын өрөөнд төрөл бүрийн хөлөгт тоглоом, бильярд, ширээний теннис зэргийг байрлуулан тогтмол ажиллуулдаг нь багш ажилтны төлөөлөл болон суралцагчидтай хийсэн ярилцлагаар нотлогдож байгаа.
- Мөн багш суралцагч нарт эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх хүчин чадалтай эмнэлэгтэй.
- Биеийн тамирын зааланд багш нарын болон суралцагчдын үнэ төлбөргүй тоглох хуваарь гарган мөрдөн ажиллуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/ Туршлага:

- Номын сан нь 24 цагийн турш ажилладаг, өндөр хурдны интернетэд холбогдсон 60 компьютертэй, эрдэм шинжилгээний номын сан нь өндөр хүчин чадал бүхий судалгааны програмууд суулгасан, 24МВ хурдтай, нээлттэй эх сурвалжуудыг ашиглах бүрэн боломжтой 20 компьютертэй байна.
- Хичээлийн байр нь бүхэлдээ өндөр хурдны интернетэд холбогдсон, үнэгүй интернеттэй.
- Хичээлийн байрны давхар бүрт ус цэвэршүүлэгч тавьж өгсөн. Багш нарын болон суралцагчдын амралтын өрөө, цайны буланг шинээр байгуулсан.
- Байгууллагын хэмжээнд ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг тогтмол хийдэг.
- Сургууль дотор байрлах кофе шоп болон буфетны бараа материалд шинжилгээ хийлгэж, ариун цэврийг хангуулах талаар гэрээнд тусгайлан тусгасан байна.

Анхаарах асуудал:

- Хууль эрх зүйн актуудын цахим санг сургуулийн цахим номын сантай холбох

Зөвлөмж:

- Сүүлийн 5 жилд хийсэн номын сангийн фондын баяжилт нь хангалттай хэмжээнд байгаа боловч магистрантуудын хэмжээнд хэрэглэх гадаадын ном сурах бичиг, мэргэжлийн сэтгүүлийн тоог нэмэгдүүлэх

3.2 Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлиггүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Багш нар сургалтын Xcloud программыг ашиглан E-хичээл болон видео хичээл бие даалт, шалгалтын асуулт, лекцийн хураангуй, презентэшн, тест, бодлого зэргийг оруулдаг нь суралцагчдад хүссэн цагтаа татан авч үзэх боломж олгодог.
- Магистрын хөтөлбөрт үзэх ёстой 13 хичээлийн 104 лекцийг презентэшн хэлбэрээр оруулан сургалтанд ашиглаж байна. Энэ нь судлах ёстой хичээлийн 100%-ийг эзэлж байгаа юм.

- Орчин үеийн сургалтад хэрэглэж буй бүх төрлийн техник хэрэгслээр хичээлийн анги танхим, захиргааны ажилтнууд, багш нар бүрэн хангагдсан.
- Багш нар хичээлдээ powerpoint, prezi, flash animation, spss програмуудыг хэрэглэж хэвшсэн байгаа нь нотлох баримтуудаас тодорхой болж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/ Туршлага:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар нь Рояль телевизтэй хамтран өөрсдийн лекцийг видео хэлбэрээр бичүүлэн монтажуулаад сургалтад хэрэглэж байна. Бүх хичээлийн лекцийн CD ийг үзэж танилцав.

Анхаарах асуудал:

- Сургалтын кино болон хууль эрх зүйн актуудыг CD-д буулган тогтмол хэрэглэх

Зөвлөмж:

- Сургалтын хэрэглэхүүнийг хийж хэрэглэхэд тавих шалгуур шаардлагыг илүү тодорхой болгох
- Сургалтад хэрэглэж байгаа цахим хэрэглэхүүнүүдээр нэгдсэн сан үүсгэх, татгалзлын дэвтэр хөтлөх

3.3 Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- ИЗОУИС нь сургалт, судалгааны 13 номын сантайгаас гадна цахим үйлчилгээний, нийтийн, эрдэм шинжилгээ судалгааны, чөлөөт сонголтын, тогтмол хэвлэлийн төрөлжсөн заал танхимуудтай.
- Номын сангууд олон улсын стандарт ISO17799:2003 “Архив, номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавигдах шаардлага стандарт”-ыг үзүүлэлтийг бүрэн хангаж ажилладаг.
- Төв номын сангийн соронзон хаалга суурилуулсан ба номуудад ялтас наасан, хяналтын камер байрлуулсан нь номыг хулгайд алдах эрсдэлээс хамгаалсан. Номын сангийн байрны гэрэлтүүлэг, барилгын дулаан чийгшил, эрүүл ахуйн нөхцөл, уншигчдад үйлчлэх байрны орчин, фонд хадгаламж, номын сангийн тоног төхөөрөмж, номын сангийн ажилтанд тавих стандарт шаардлага зэргийг ханган ажиллаж байна.
- ИЗОУИС-д нийт 12 номын санч, 1 ном сэлбэн засагч ажилладаг. Бүгд мэргэжлийн номын санчид үүнээс магистр 1, бакалаврын зэрэгтэй 9, тусгай дунд боловсролтой 3 байна.

- ИЗОУИС -ийн номын санд нийт 18,721 нэр төрлийн 68,842 ширхэг ном, сурах бичиг, гарын авлага байна. Үүнээс магистрын болон бакалаврын дипломын ажил 2100 гаруй байна. Электрон хувилбарт нийтдээ 600 гаруй ном, сурах бичиг орсон бөгөөд суралцагчийн цахим хэлбэрээр ном унших ажлыг дэмжин ажиллаж байна. Цахим хувилбартай ном, сурах бичгийг оюутан суралцагчид интернэт орчноос номын сангийн хаягаар нэвтрэн унших бүрэн боломжтой. Номын сангийн хаяг: 103.14.37.39
- ИЗОУИС-ийн номын сангийн хэмжээнд сүлжээнд холбогдсон 40 компьютер бүхий электрон уншлагын танхимтай. Номын сангаас өдөрт 700-800 уншигч уншлагын танхимаар болон гэрээр 1500-2000 гаруй ном, сурах бичиг, гарын авлага бусад хэвлэмэл материалаар үйлчлүүлж байна.
- Электрон каталогид өдөрт 1000-1500 удаагийн хандалт хийж уншигчид ашиглаж байна.
- Нэг суралцагчид оногдох ном сурах бичгийн тоо 25, гадаад дотоодын тогтмол хэвлэлийн тоо 33 байна.
- Номын фондын ашиглалтын байдал нь мэргэжлийн ном сурах бичгийн хувьд өндөр, фондын эргэлт 100 хувьтай байна.
- Бүх мэргэжлийн ном сурах бичгийг Lib4U програмаар электрон каталогид оруулсан, PDF хувилбараар 550 гаруй нэрийн ном сурах бичиг, мэргэжлийн сэтгүүлийг электрон хэлбэрт оруулсан.
- Сүүлийн 5 жилд хууль эрх зүйн чиглэлээр 348 нэр төрлийн 2232 номоор фондоо баяжуулсан байна.
- Магистрын судалгааны ажлуудыг Степпелинг ХХК-тай гэрээлэн контент хэлбэрээр ESAN буюу цахим санд оруулуулан магистрантуудад үйлчилж байна. Одоогийн байдлаар нийт 1136 магистрын судалгааны ажлыг тус сандаа бүртгээд байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай ном сурах бичиг, гарын авлага, мэргэжлийн сэтгүүл зэрэг сургалтын хэрэглэхүүний баяжилт, фондын бүрдүүлэлт хийхдээ, тус хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нар, хөтөлбөрийн хорооны санал, судалгаанд үндэслэн хичээлийн жилийн эхэнд хийдэг нь хөтөлбөрийн агуулга,арга зүй, хөтөлбөрийн үр дүнтэй нийцэж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/ Туршлага:

- Номын сангийн нэг оюутанд оногдох талбайн хэмжээ, номын тоо зэрэг нь хангалттай сайн
- Жил бүр тогтмол номын баяжилт хийдэг.
- Цахим ном сурах бичиг, судалгааны ажил, мэргэжлийн сэтгүүлүүд хангалттай сайн.
- ИЗОУИС-ийн төв номын сан нь 24 цагаар ажилладаг учраас ажил эрхлэнгээ суралцдаг магистрантуудад тохиромжтой байдаг.

- Мөн цахим номын сангаар хаанаас ч хэзээ ч үйлчлүүлж болдог нь суралцагчдын сэтгэл ханамжийг өргөдөг. Эдгээр нь суралцагчдаас авсан сүүлийн 5 жилийн сэтгэл ханамжийн судалгаанд тогтмол эерэг хариулт өгсөн байгаагаар нотлогдож байна.
- Монголын Үндэсний номын сан, УБ хотын төв номын сан, БЗД-ийн 3 дугаар номын сан, ХИС-ийн харьяа Билиг дээд сургуулийн номын сангуудтай номын солилцоо хийж ажилладаг нь татгалзлын болон ашиглалтын бүртгэлийн дэвтэрийн тэмдэглэлээр батлагдаж байна.

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн сэтгүүлүүдийг нэмэгдүүлэх
- Гадаадын ном сурах бичгийн захиалгыг тогтмол болгох

Зөвлөмж:

- Гадаад дотоодын бусад сургуулиудын номын сангийн тэргүүн туршлагыг нэвтрүүлэх

3-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: **БҮРЭН ХАНГАСАН**

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилах, хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1 Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- ИЗОУИС нь удирдлагын босоо тогтолцоотой ба шийдвэр гаргах дээд байгууллага нь ИЗОУИС-ийн Удирдах зөвлөл байна.
- Их Засаг ОУИС нь I проректороор ахлуулсан хөтөлбөрийн хороо, хөтөлбөрийн багийн удирдагчдаар ахлуулсан хөтөлбөрийн дэд хороо /Хөтөлбөрийн баг/-ны зохион байгуулалтаар ажилладаг байна. Удирдах зөвлөлийн хурлаар хөтөлбөрийн хорооны журмыг шинэчлэн баталсан. Хөтөлбөрийн хорооны журмаар хөтөлбөрийн хорооны зорилго, бүтэц, бүрэлдэхүүн, удирдлага зохион байгуулалт, чиг үүрэг, тавигдах шаардлага болон үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулдаг.
- Эрх зүйн магистрын сургалтын хөтөлбөрт оруулах санал, зөвлөмжөө багш нар дэд хорооны хуралд оруулаад гарсан шийдвэрээ хөтөлбөрийн хорооны хурлаар оруулдаг учраас нийт багш нарын санал, бодол тусгагдах бүрэн боломжтой байна.
- Тухайн хичээлийн жилийн ажлын төлөвлөгөөг хичээлийн жилийн эхэнд гарган хөтөлбөрийн дэд хороод дээр хэлэлцэж үзээд хөтөлбөрийн хороонд уламжлан батлуулан мөрдөж ажилладаг байна. Мөн жил бүрийн 1, 5-р сард хөтөлбөрийн дэд хороодын удирдагч нар тухайн хугацаанд хийсэн ажлын тайлан мэдээг

хөтөлбөрийн хорооны хурлаар хэлэлцүүлж хэвшсэн байгаа нь хөтөлбөрийн хороодын хурлын тэмдэглэл, хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, хурлаас гарсан шийдвэр зэргээр нотлогдож байна.

- Эрх зүйн магистрын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчин бүрдсэн.
- Жил бүр багш, суралцагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авдаг. Энэ нь Их Засаг ОУИС-ийн оюутнаас санал асуулга авах журмаар зохицуулагдана. Судалгааны үр дүн дүгнэлтэд үндэслэн асуудлыг сайжруулах, боловсронгуй болгох тал дээр хөтөлбөрийн хороод, сургуулийн удирлагын зүгээс анхааран ажлын төлөвлөгөөндөө тусган ажилладаг.
- Суралцагчаас ирсэн санал, хүсэлт, гомдлыг барагдуулахдаа Хөдөлмөрийн тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, ИЗОУИС-ийн дүрэм, журмууд, магистрын сургалтын журам зэргийг удирдлага болгон ажилладаг. Ямар асуудлаар хандсанаас нь шалтгаалан зохицуулах бүх эрх зүйн акт баримт бичгүүдийг боловсруулан хэрэгжүүлдэг.
- Багшаас ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг тухайн сургуулийн захирал хүлээн авч, өөрийн эрх мэдлийн хүрээнд бол шийдвэрлэж өгнө. Шаардлагатай тохиолдолд багш ажилтны ёс зүйн хороонд ханддаг. Энэ нь ИЗОУИС-ийн багш ажилтны ёс зүйн дүрмээр зохицуулагдана.
- Сургуулийн удирдлагаас нэгдсэн мэдээллийг дамжуулахдаа багшийн болон оюутны програмыг ашиглан <http://teacher-web.xcloud.mn/login>, <http://student-web.xcloud.mn/login>, <http://monitor.xcloud.mn/login> нийцүүлэн хөрвүүлэлт хийн ажиллагаанд оруулан суурь мэдээллийн сангийн бүрдэл болон боловсруулалтыг гүйцэтгэн ажиллаж байна.
- Нийт багш ажилтнуудын ажлын цагийн мэдээллийг хурууны хээгээр бүртгэлжүүлэн цахимаар нэгтгэн боловсруулдаг нь ажлын цагийн нягтрал, тайлагналтыг тодорхой болгосон нь цаг ашиглалт, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлсэн байна.
- Багш ажилтнууд нь цахим шуудангийн хаягаараа дамжуулан албан ажлын мэдээллүүдийг өөрийн байгууллага дотроо болон гадаад дотоодын байгууллагатай мэдээлэл солилцоход ашигладаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/ Туршлага:

- ШУС-ийн сургалтын үйл ажиллагаанд ИЗОУИС-ийн эрхэм зорилго, алсын хараанд нийцүүлэн, тухайн жилийн ИЗОУИС-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон 2030 он хүртэлх стратеги төлөвлөгөөг мөрдлөг болгон ажлаж байна.

Анхаарах асуудал:

- Сургалтын мэдээллийн системийг удирдлагын мэдээллийн системийн түвшинд ашиглах

Зөвлөмж:

- Удирдлагын мэдээллийн системийг бүрэн ажиллагаанд оруулах

4.2 Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон төрийн бус байгууллагатай холбоо тогтоож, багш суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- ИЗОУИС-ийн гадаад харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлыг хариуцсан нэгж буюу гадаад харилцааны алба ажиллаж, гадаадын улс орон болон дотоодын бусад их сургууль, төрийн ба төрийн бус байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр зохион байгуулалтын ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна. Тус албыг гадаад харилцаа хамтын ажиллагаа эрхэлсэн захирал удирдаж орон тооны хоёр мэргэжилтэн ажиллаж байна.
- Сүүлийн 5 жилийн хугацаанд гадаад харилцаа хамтын ажиллагаанд нэлээд их ахиц дэвшил гарсан байгаа нь гадаад харилцаа хамтын ажиллагааны албаны ажлын төлөвлөгөө түүний хэрэгжилтээр нотлогдож байна.
- Их Засаг Олон Улсын Их Сургууль үүсэн байгуулагдсан цагаасаа эхлэн гадаадын их, дээд сургууль, байгууллагуудтай нээлттэй, идэвхтэй, бодит зарчмын үндсэн дээр хамтран ажиллаж байна. Тус их сургууль ОХУ, БНХАУ, АНУ, Япон, БНСУ, ХБНГУ, Их Британи, Австрали, Турк, Кипр, Сингапур, Филиппин, Малайз зэрэг орны 50 гаруй их, дээд сургууль, байгууллагатай багш солилцох, бакалавр, магистрын болон сертификатын сургалт, судалгаа, шинжилгээний төслүүд хэрэгжүүлэх, олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, харилцан туршлага солилцох зэрэг олон хэлбэрээр хамтран ажиллаж байна.
- 2015-2020 оны хичээлийн жилийн хугацаанд ШУС өнгөрсөн онуудад эхлүүлсэн гадаад хамтын ажиллагааны гэрээ болон Их Засаг ОУИС -ийн хамтын ажиллагааны гэрээт гадны сургуулиуд болон олон улсын байгууллагуудтай гэрээнд тусгагдсан хамтын ажиллагааг амжилттай үргэлжлүүлэн, зарим сургуулиудтай ажиллах хамтын ажиллагааны гэрээний хугацааг сунгаж, түүнчлэн хэд хэдэн шинэ байгууллагуудтай харилцан ойлголцолын санамж бичигт гарын үсэг зурсан байна.
- Мөн сүүлийн 5 жилд ШУС-ийн багш нараас 9 багш 12 удаа гадаад улс оронд болсон сургалт, эрдэм шинжилгээний хурлуудад оролцсон байна.
- Шинжлэх Ухааны сургуульд магистрын хөтөлбөрийг боловсруулахдаа гадаадын зарим улс орны ижил төстэй их дээд сургуулиудын туршлагыг тодорхой хэмжээгээр тусгахыг чармайсан байна. Тухайлбал: Бүгд Найрамдах Солонгос, Улсын Сүнгшилийн их сургууль, Какахстаны Кекшүтаугийн их сургууль, ОХУ-ын Буриадын их сургууль, БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны хууль цаазын их сургууль зэрэг болно.

- Тус сургууль хөтөлбөрийн чанараа сайжруулах, төгсөгчдийн ажил эрхлэлтийг дэмжих, зорилгын үүднээс мэргэжлийн холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж ирсэн байна. Тухайлбал, магистрын хөтөлбөрийн шинэчлэлт, магадлан итгэмжлүүлсэн туршлага, сургалтын чанар, агуулгын талаар Монгол Улсын Их Сургууль, Дотоод хэргийн их сургууль, Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Шихихутаг их сургуулийн туршлагыг судлах ажлыг зохион байгуулсан нь гадаад харилцаа, хамтын ажиллагаа өргөжин сургалтын хөтөлбөрийн агуулга, стандартыг боловсронгуй болгох хөшүүрэг болсон байна.
- Дээрх илрэл нотолгоонууд нь хамтран ажиллах гэрээ, санамж бичгүүд болон түүний дагуу хийсэн ажлын тайлангаар нотлогдож байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/ Туршлага:

- Гадаадад томилолтоор явсан багш нар харилцан туршлага солилцож, хичээлийн агуулга, арга зүй, үнэлгээний арга зүйн талаар сайжруулах санал төсөл боловсруулж ирсэн нь хөтөлбөрийн чанарт үр дүнгээ өгч байна.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нар нь мэргэжлийн холбоод, хороо, зөвлөл, нийгэмлэгийн тэргүүн, гишүүн, удирдах зөвлөлийн гишүүн зэргээр ажиллаж байгаа нь тус хамт олны эрдэм шинжилгээний ажлын үр дүнгийн нэгэн илрэл гэж үзэж байна.

Анхаарах асуудал:

- Гадаад харилцаа, хамтын ажиллагааны талаар эрх зүйн акт баримт бичгүүд хангалттай ч, зохих стандарт шаардлагын дагуу үйлдэхэд анхаарах

Зөвлөмж:

- Сургалт, эрдэм шинжилгээний хуралд оролцох багшийг сонгон шалгаруулах журам боловсруулж, мөрдлөг болгох

4.3 Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтын тодорхой хувь нь багш, оюутны хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Их Засаг ОУИС-ийн нэгдсэн төсөв нь хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжүүдийн төсвөөс бүрдэх бөгөөд, нэгдсэн төсвийг УЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, санхүүгийн үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажилладаг. Гүйцэтгэлд нь сургуулийн захирал хяналт тавин ажиллаж УЗ-ийн хуралд тайлагнадаг байна. Төсөвт эрдэм шинжилгээ, судалгаа, багшийн хөгжилд зарцуулагдах зардлыг тусгасан байна
- 2005 он хүртэл нягтлан бодох бүртгэлийн Ругamid програмыг ашигладаг байсан. 2015 оноос Ай Би Ай компаний Diamond 5,0 програм, цалингийн Payroll програм ашигладаг болсон нь цаг тухай бүрт гүйцэтгэлд хяналт тавих боломжтой, тайлан

мэдээ гаргах, удирдлагыг санхүүгийн мэдээллээр хангах үйл ажиллагааг хялбаршуулсан зэрэг давуу талыг буй болгосон байна.

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж нь үйл ажиллагааны төлөвлөгөөнийхөө дагуу төсөвт санал оруулах, захиалга, шаардлага хэрэгцээний судалгаа гаргаж, шаардлагатай техник хэрэгсэл, сургалтын орчин, хэрэглэгдэхүүнийг сайжруулах материаллаг зүйлсийг авах зэрэг асуудлыг шийдвэрлэх боломжтой байдлаар төсөв батлагддаг байна. Ингэснээр хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь санхүүгийн тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагааг тасралтгүй хөгжүүлэн, өргөжүүлэх боломжтой болдог байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийн дийлэнх хувийг сургалтын төлбөр эзэлж байгаа бөгөөд төлбөрийн хэмжээг тухайн үеийн инфляцийн түвшин, нэг оюутанд ноогдох зардалд үндэслэн, жил бүр ИЗОУИС-ийн УЗ-ийн хурлаар хэлэлцэн баталдаг. Эрх зүйн магистрын хөтөлбөрийн сургалтын төлбөр сүүлийн 3 жилд тогтвортой байсан байна.
- Хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор багш нарт зориулан эрдэм шинжилгээ судалгааны ажлын нэмэгдэл, ажилласан жилийн нэмэгдэл, ном сурах бичиг, бүтээлийн урамшуулал, багшийн хөгжлийг дэмжин дотоод гадаадын сургалт семинар, эрдэм шинжилгээний хуралд оролцох зардал олгох, эрдмийн зэрэг хамгаалахад нь 6 хүртэл сарын цалинтай чөлөө олгох зэргээр дэмжлэг үзүүлдэг байна. Мөн ИЗОУИС-ийн харьяа байгууллагуудаар /Тэмүүжин, Гоц жаалууд цэцэрлэг, Их Засаг лицей сургууль, Роял академи, Жуулчны баазууд гэх мэт/ үйлчлүүлэхдээ 30-50 хувийн хөнгөлөлт эдэлдэг байна.
- Дээрх илрэлүүд нь холбогдох санхүүгийн баримтаар нотлогдож байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/ Туршлага:

- Жил бүрийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитын байгууллагаар хянуулан ажиллаж хэвшсэн байна.
- Багш, суралцагчдад олгодог урамшууллын тогтолцоо жигдэрсэн. Сүүлийн 5 жилд суралцагчдад үзүүлсэн сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд нийт сургалтын төлбөрийн 10 хувийг зарцуулсан байна.
- Багш ажилдын нийгмийн асуудлыг шийдэх зорилгоор 2016-2017 оны хичээлийн жилд 63 айлын 9 давхар орон сууц барин багш ажилчиддаа хүүгүй зээл, хөнгөлөлттэй нөхцөлөөр олгосон байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг сургалтын төлбөрөөр бүрдүүлж байна

Зөвлөмж:

- Орлого бүрдүүлэлтийн олон эх үүсвэртэй болох

4.4 Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц маркетинг идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй.

Илрэл нотолгоо:

- ИЗОУИС нь 2014 оноос эхлэн маркетингийн албыг 6 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулжээ. Маркетингийн алба нь сургуулийн соёл, олон нийт, спорт, төрөл бүрийн тэмцээн, уралдаан, ЭШХ-уудыг багш нартай хамтран зохион байгуулдаг.
- Их Засаг ОУИС-ийн Шинжлэх ухааны сургууль нь сургалтын бодлого, чанарын алба, маркетингийн албатай хамтран жил бүр хөтөлбөрийн маркетингийн идэвхижүүлэлтийг хийж, төлөвлөгөө гарган ажилладаг
- Магистрын хөтөлбөрийн суралцагчдад онцгой сэтгэгдэл үлдээх идэвхжүүлэлтийн үйл ажиллагааг батлагдсан төлөвлөгөө, графикийн дагуу хийж гүйцэтгэж байна.
- Хувь хүний хөгжил, хамтын ажиллагааг дэмжсэн энэхүү үйл ажиллагааны үр дүнд магистрын хөтөлбөрийн элсэлт тогтвортой байдаг.
- Хөтөлбөрийн зах зээлийн тандан судалгаа нь бидний хувьд нийгмийн шаардлагыг мэдэрч, эрх зүйн магистрын хөтөлбөрийг боловсронгуй болгох, түүний сул талыг засч сайжруулах зэрэг сургалт, эрдэм шинжилгээний хэд хэдэн асуудалд чухал үүрэгтэй байдаг. Энэхүү хөтөлбөрийг ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг их дээд сургуулиудын хөтөлбөртэй харьцуулах, улам хөгжүүлэх, давуу талыг нэмэгдүүлэх чиглэлд маркетингийн үйл ажиллагаа анхаардаг.
- Эрх зүйн магистрын хөтөлбөрийн нийгмийн эрэлт хэрэгцээ, шаардлага, суралцагчийн хүсэл сонирхол, ажил олгогчийн захиалга, саналыг харгалзан хөтөлбөрийн сурталчилгаа, идэвхжүүлэлтийн ажлыг тодорхой төлөвлөгөө, алхмаар тасралтгүй, байнга явуулдаг. Контент маркетинг, Loyalty /урамшуулал/, Эвэнт маркетинг гэсэн үндсэн 3 чиглэлээр маркетингийн идэвхжүүлэлтийг хийдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/ Туршлага:

- Сургуулийн эрхэм зорилгыг хангах, сургалтын чанарыг сайжруулах зорилгоор багш, суралцагчдаа ОУЭШХ, семинарт явуулахыг бодлогоор дэмждэг.

Анхаарах асуудал:

- Аль болох олон багш, суралцагчийг сургалт, семинар, ОУЭШХ-д хамруулж байх, /Нэг багшийн давтамжийг цөөлөх/

Зөвлөмж:

- Брэнд бүүкээ хэвлэх

4.5 Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Өдөр тутмын болон цаг үеийн шинжтэй үйл ажиллагаандаа <http://www.ikh.zasag.edu.mn/mn/>, Fb;багш нар, ШУС-ийнхан, <http://www.tw.xcloud.mn>, <http://www.sw-beta.xcloud.mn> зэрэг цахим хаягуудыг ашигладаг байна.
- Хөтөлбөрийн багш нар сургалт, эрдэм шинжилгээ, инноваци, олон нийтэд чиглэсэн болон урлаг, спорт зэрэг бусад зохион байгуулж буй ажлуудаа Их Засаг ОУИС, ШУС-ийн вэб сайтуудаар мөн өөрсдийн төгсөгчдийн нүүр номын бүлгээр дамжуулан түгээдэг
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л мэдээллийг агуулсан “Магистрантын гарын авлага”, “Дүрэм журмын эмхэтгэл”-ээр хангадаг.
- ISO 9001:2015-ыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.
- Их Засаг сонин улирал тутамд гаргадаг.
- Мөн магистрантуудын их семинар болон ЭШБХ-уудад хэлэлцэгдсэн илтгэлүүдээр тухай бүр нь эмхэтгэл гаргадаг. Жилд дунджаар 3-4 хурал зохион байгуулж, эмхэтгэлийг нь гаргаж байна.
- Их Засаг онол арга зүйн сэтгүүлийг улирал тутам гаргаж, багш судлаач нар болон магистрантуудынхаа бүтээлийг хэвлэн хэвлэн нийтийн хүртээл болгодог байна. Энэ нь сургууль дээр ажиллах үед нотлох баримтаар батлагдсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/ Туршлага:

- Багш, суралцагч, сургуулийн захиргааны хийж хэрэгжүүлж буй эсвэл төлөвлөж буй ажлыг нийтэд хүргэх цахим мэдээлийн үйл ажиллагаа жигдэрсэн.
- Рояль телевизтэй байнга хамтран ажиллаж, сургуулийнхаа бодлого, үйл ажиллагааны чиглэлээ олон нийтэд мэдээлж байдаг.

Анхаарах асуудал:

- Нийгэмд чиглэсэн үйл ажиллагаагаар эрх зүйн магистрын хөтөлбөрийг сурталчлах

Зөвлөмж:

- Нээлттэй ил тод байдлыг хангах ажлын биелэлтийг тодорхой хугацаанд дүгнэн тооцож байх

4-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган өие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1 Элсэлтийн бодлого, дүрэм журам

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчдыг элсүүлэн суралцуулах эрх зүйн орчин бүрдсэн. Түүний хэрэгжилт хангалттай сайн. Магистрантуудад зориулсан гарын авлага, мэдээлэл хангалттай. Хүсэлт гаргасан оюутнуудаас шаардлага хангаагүй, шалгалтанд тэнцээгүй оюутнуудыг хасч журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Элсэлтийн үйл ажиллагаа нь дараах баримт бичгүүдээр нотлогдож байна.
- ИЗОУИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2019.12.11-ний өдрийн тогтоолоор батлагдсан ИЗОУИС-ийн магистрын сургалт эрхлэх журам
- 2019-2020 оны хичээлийн жилд ИЗОУИС-ийн ШУС-д суралцагч элсүүлсэн журам
- Эрдмийн сургуулийн 2017 оны 05 дугаар сарын 12, 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн, ШУС-ийн 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн элсэгчдийн тоо төлөвлөх санал,
- ИЗОУИС-ийн Удирдах зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/8, 2018 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/6, 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/4 дугаартай Элсэлтийн хяналтын тоо батлах тухай тогтоол,
- ИЗОУИС-ийн Ректорын 2015 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/173, ИЗОУИС-ийн Ректорын 2016 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/36, 2017 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/79, 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/124, 2018 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/107 дугаартай Эрдмийн сургуульд оюутан элсүүлэх тушаал,
- ИЗОУИС-ийн Ректорын 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/27, 2019 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/72 дугаартай ШУС-д оюутан элсүүлэх тушаал,
- 2017-2018 оны хичээлийн жилд Эрдмийн сургуулийн магистрын элсэгчдэд зориулсан гарын авлага
- 2019-2020 оны хичээлийн жилд Шинжлэх ухааны сургуулийн магистрын элсэгчдэд зориулсан гарын авлага
- 2001-2020 оны хооронд ИЗОУИС-ийн ШУС-д Эрх зүйн магистрын зэрэг хамгаалсан сэдвүүдийн гарчигийн хэлхээс /гарын авлага/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/ Туршлага:

- Сургалтын алба нь багш нараас оролцуулан элсэлтийг зохион байгуулж, элсэгч болон төгсөгчийн нэгдсэн судалгааг хийж мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж байна.
- Мэдээллийн нэгдсэн сан дээр тулгуурлан анализ хийж ажилладаг байна. Бүртгүүлсэн болон элсэн орсон суралцагчийн тоон мэдээ, хөнгөлөлт эдэлсэн суралцагчийн тоо, курс дэвшсэн суралцагчийн тоо зэрэгт анализ хийсэн байна.
- Шинээр элсэгчдэд сургалтын төлбөрийн хөнгөлөлт, урамшууллын бодлого явуулж элсэгчдийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байна.
- ШУС-д суралцагч элсүүлэх дүрэм журам болон элсэгчдэд зориулсан сурталчилгаа, мэдээллийг цахим орчин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр өгдөг байна.

- Шинээр элсэгчдэд зориулсан “Магистрантын гарын авлага”-ыг хэвлэж түгээхийн зэрэгцээ, номын сан, сургуулийн коридор, амралтын өрөө зэрэгт байрлуулан хэрэглүүлж байна.
- Хөтөлбөрийг өөрчлөн шинэчлэх бүрт гарын авлагыг шинэчлэн гаргадаг.

Анхаарах асуудал:

- Гадаад суралцагч элсүүлэх

Зөвлөмж:

- Гадаад харилцаа холбоогоо ашиглан гадаад оюутнууд элсүүлэх бүрэн боломжтой.

5.2 Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Эрдэм шинжилгээний ажлын нэгдсэн төлөвлөгөөг жил бүрээр гаргаж батлуулсан байх бөгөөд үүний дагуу төрөл бүрийн ЭШХ-ыг зохион байгуулж хэвшсэн байна.
- ЭШХ болон их семинарт хэлэлцүүлсэн шилдэг илтгэлүүдийг нэгтгэн эмхэтгэл гаргадаг.
- Зөвлөн туслах үйлчилгээний хуваарь, төлөвлөгөө
- Магистрын гарын авлага
- Эрдэм шинжилгээний Их семинар зохион байгуулах журам, ажлын тайлан мэдээ
- Эрх зүйн магистрантуудад өгөх семинар зөвлөгөөний төлөвлөгөө, хуваарь, тайлан
- Эрх зүйн магистрантуудад зөвлөн туслах төлөвлөгөө, хуваарь, тайлан
- ИЗОУИС-ийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын төлөвлөгөө, тайлан
- Эрх зүйн магистрантуудаас авсан сэтгэл ханамжийн судалгааны тайлан
- Сэтгэл ханамжийн судалгааны дата мэдээлэл

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/ Туршлага:

- Суралцагчийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч, холбогдох нэгжид гарсан үр дүнг танилцуулах, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх сайжруулалт хийх үүрэг даалгаврыг АГҮБ-аас өгч, холбогдох нэгжүүд төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлдэг байна.
- Зөвлөн туслах үйлчилгээний хуваарь, төлөвлөгөөтэй

Анхаарах асуудал:

- Зөвлөн туслах үйлчилгээний хүртээмжид анхаарах

Зөвлөмж:

- Зөвлөн туслах үйлчилгээний хүртээмжийг сайжруулах

5.3 Суралцагчдын олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Их сургуулийн дэргэдэх клиник сургалтын төв болон профессорын багтай хамтран судалгааны ажил болон дипломын сэдвийн хэлэлцүүлэгүүдийг зохион байгуулж идэвх санаачлага гарган ажиллаж байна.
- ШУС нь жил бүрийн 10-11 дүгээр сард сургуулийн бүх оюутны дунд спортын арга хэмжээ зохион байгуулж, оюутан бүрийн идэвх оролцоог сайжруулж олон нийтийн арга хэмжээг зохион байгуулж байна.
- Суралцагчдад төрөл бүрийн хөнгөлөлт, урамшуулал олгодог бөгөөд сүүлийн 5 жилд тус хөтөлбөрөөр суралцагчдаас 113 суралцагч 68,960,000 төгрөгийн урамшуулал, хөнгөлөлт эдэлсэн байна.
- Мөн Боловсролын зээлийн сангаас хөнгөлөлттэй зээлэнд хамрагдаж болно.
- Бакалавраар төгсөөд магистрантурт суралцаж байгаа төгсөгчийн хүүхдүүдийг “Тэмүүжин” цэцэрлэгт хөнгөлөлттэй үнээр сургана.
- Мөн “Их Засаг” лицей сургуулийн сургалтын төлбөрөөс хөнгөлдөг байна.
- 2017-2018, 2018-2019, 2019-2020 оны хичээлийн жилд Эрдмийн сургууль /ШУС/-ийн эрх зүйн магистрын ангиудаас зохион байгуулсан Спорт өдөрлөгийн удирдамж, тайлан
- ИЗОУИС-ийн Оюутны намар-2017 урлагийн их наадмийн бэлтгэл ажлын төлөвлөгөө, удирдамж, тайлан
- ИЗОУИС-ийн Спортын Бага олимп-2019 наадмийн удирдамж, хуваарь, тайлан
- ИЗОУИС-ийн Ректорын 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/89 дугаартай Эрдмийн сургуулийн 2015-2016 оны хичээлийн жилд, 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/56 дугаартай Эрдмийн сургуулийн 2016-2017 оны хичээлийн жилд, 2018 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/66 дугаартай Эрдмийн сургуулийн 2017-2018 оны хичээлийн жилд, 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/72 дугаартай Эрдмийн сургуулийн 2018-2019 оны хичээлийн жилд, 2020 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/58 дугаартай Шинжлэх ухааны сургуулийн 2019-2020 оны хичээлийн жилд сургалтын төлбөрийн хөнгөлөлт магистрантуудын нэрс батлах тухай тушаалууд
- Сүүлийн 5 жилд сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдэлсэн тайлан зэрэг баримт бичгүүдээр нотлогдож байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/ Туршлага:

- Оюутнуудын олон нийтийн оролцоо сайн. Сургуулийн зүгээс суралцагчийн, төгсөгчдийн хөнгөлөлт болон багш ажилчдын хөнгөлөлт олгодог. Мөн төрийн сангийн зээлд хамруулж төлбөрийн хөнгөлөлт үзүүлдэг байна.

Зөвлөмж:

- Суралцагчдийн олон нийтийн үйл ажиллагаа болон судалгааны ажлын үр дүнг нэмэгдүүлэхийн тулд клубуудыг ажиллуулах /ажлын цаг болон суралцах цагийг нь хүндэтгэн үзэх/

5.4 Суралцагчийн шилжилт хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх / холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Шилжилт хөдөлгөөнийг холбогдох дүрэм, журамд заасны дагуу Ректорын тушаал гарган албажуулж, түүний хэрэгжилтэнд хяналт тавьж ажилладаг.
- Тус хөтөлбөрөөр суралцагчдын шилжилт хөдөлгөөн харьцангуй бага тогтвортой байдаг нь судалгаанаас харагдаж байна.
- Сүүлийн 5 жилийн шилжилт хөдөлгөөний тоон мэдээг авч үзвэл жил ирэх бүрт буурч байгаа нь эрх зүйн магистын хөтөлбөрт суралцагч нь тухайн сургалтад тогтвортой, цаг алдалгүй суралцахыг эрмэлзэж байгаа нь харагдаж байна.
- ИЗОУИС-ийн Ректорын 2016 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/92, 2017 оны 04 дүгээр сарын 22-ний өдрийн А/49, 2018 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/56 дугаартай Эрдмийн сургуульд суралцагчдын шилжилт хөдөлгөөнийг батлах тухай тушаал, 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/34 дугаартай, 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/10 дугаартай ШУС-ийн Шилжилт хөдөлгөөнийг батлах тухай тушаалууд
- Сүүлийн 5 жилийн шилжилт хөдөлгөөний харьцуулсан судалгаа, тайлан зэрэг баримт бичгүүдээр нотлогдож байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/ Туршлага:

- Шилжилт хөдөлгөөний тоон судалгааг нарийн хийж, учир шалтгааныг тодруулан, судалгаатай ажиллаж байна. Жилийн чөлөө авах болон, жилийн чөлөөнөөс ирэх хөдөлгөөн нэлээд их байна.

Анхаарах асуудал:

- Сургуулиас гарч буй тоо нэлээд өндөр байна.

Зөвлөмж:

- Сургуулиас гарч буй тоо нэлээд өндөр байгаад анализ хийн, арга хэмжээ ажлыг зохион байгуулах

5.5 Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Магистрын зэргийн сургалтыг амжилттай дүүргэн зохих шаардлагуудыг биелүүлсэн суралцагчдад Эрдмийн зөвлөлийн тогтоолыг үндэслэн боловсролын зэргийг гэрчлэх төгсөлтийн баримт бичиг болох диплом, энгэрийн тэмдгийг Ректорын тушаалаар олгоно.
- Төгсөгчийн диплом нь ИЗОУИС-ийн Удирдах Зөвлөлийн дэд дарга, Ректор, хамгаалуулах зөвлөлийн дарга, хамгаалуулах зөвлөлийн нарийн бичгийн даргын гарын үсэг, сургуулийн тэмдгээр баталгаажих ба бүртгэлийн дугаартай байна.
- Диплом нь хавсралттай байх ба хавсралтанд суралцах хугацаанд судалсан хичээлүүд, хичээлийн кредит үнэлгээ, голч дүн, магистрын диплом хамгаалсан сэдвийг бичсэн байна.
- Дипломын хавсралт нь салбар сургуулийн захирал, сургалтын албаны даргын гарын үсэг, сургуулийн тэмдгээр баталгааждаг.
- Төгсөгчийн хаяж үрэгдүүлсэн дипломыг дахин олгох эсэх асуудлыг “Их Засаг ОУИС-ийн диплом олгох журам”-ын дагуу шийдвэрлэнэ.
- Их Засаг ОУИС-ийн диплом олгохдоо Монгол Улсын Боловсролын тухай хууль, дээд боловсролын тухай хууль, Боловсрол Соёл, Шинжлэх Ухааны сайдын 2002 оны 355 дугаар тушаалын заалтыг үндэслэн төгсөгчдөд дээд боловсролын тодорхой шатны агуулга эзэмшсэнийг гэрчилсэн магистрын зэргийн диплом олгодог.
- Их Засаг ОУИСургуулийн Ректорын 2015 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/187 тоот тушаалаар батлагдсан Сургалтын журам/ төгсөлтийн талаарх заалтууд/
- Их Засаг ОУИСургуулийн Ректорын 2016 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/15, 2016 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/25, 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/22, 2018 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/14, 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/73, 2019 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/05, 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/35, 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/71 дугаартай Эрдмийн сургууль болон ШУС-ийн магистрын төгсөгчдөд диплом, энгэрийн тэмдэг олгох тухай тушаалууд
- БСШУСЯ-ны Дээд боловсролын газарт дипломын дугаар хүссэн албан бичгийн хуулбар
- Төгсөгчдийн дипломын хуулбар зэрэг баримт бичгүүдээр нотлогдож байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/ Туршлага:

- Магистрын зэргийн сургалтыг амжилттай дүүргэн зохих шаардлагуудыг биелүүлсэн суралцагчдад Эрдмийн зөвлөлийн тогтоолыг үндэслэн боловсролын зэргийг гэрчлэх төгсөлтийн баримт бичиг болох диплом, энгэрийн тэмдгийг Ректорын тушаалаар олгодог.
- Диплом болон хавсралтыг кирилл, англи, монгол бичгээр хэвлэдэг.

- Сургуулийн архивт хамгаалуулах зөвлөлийн хурлын тогтоол, тэмдэглэл, диплом олгосон бүртгэлийн хуулбар, удирдагчийн тодорхойлолт, дипломын хуулбар зэргийг суралцагч бүрээр авч үлдэн хадгалан хамгаалдаг.

Анхаарах асуудал:

- Төгсөлтийн баримт бичигт мэргэжлийн индексийг бичих

Зөвлөмж:

- Төгсөлтийн баримт бичгийн бүрдүүлбэр, сургуулиас ологосон баримт бичгийг төгсөгч бүр цахим хэлбэрээр хүссэн цагтаа татаж хэрэглэх боломжийг судлах

5- р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: **БҮРЭН ХАНГАСАН**

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хагжүүлэхэд чиглэсэн байна.

6.1 Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, маргажлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Их Засаг ШУСургууль нь Их Засаг ОУИС-ийн хэмжээнд мөрдөгддөг “Их Засаг ОУИС-д багш, ажилтан сонгон шалгаруулж авах журам”, “Багш, ажилтны ажлын байрны тодорхойлолт” зэрэг холбогдох дүрэм, журам, хуульд нийцүүлэн тухайн хичээлийн жилд ажилласан багшийн жилийн ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэх, дараагийн жилийн суралцагчдын болон багшийн тоон харьцуулалтын судалгаа, багшийн цагийн ачаалал зэрэгт суурилан шинээр багш ажилтан авах асуудлын талаарх саналаа Хүний нөөцийн албанд хүргүүлдэг. Хүний нөөцийн алба багшийн нөөцөө нээлттэй бүрдүүлдэг.
- Шинээр багш ажилтанг авахдаа доктор, дэд профессор, профессор зэрэгтэй судалгаа шинжилгээний бүтээл, судалгааны ажлуудтай, гадаадын их дээд сургуульд бэлтгэгдсэн эсэх, дотоод гадаад эх үүсвэр зэргээс хамааран Хүний нөөцийн алба сонгон шалгаруулалт хийдэг. Нийт 5 үе шаттай байна.
- Эрх зүйн магистрын хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа багш нар Дээд боловсролын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.”Их сургуульд магистр, докторын хөтөлбөрийн хичээлийг докторын зэрэгтэй багш заана” гэж заасныг мөрдлөг болгон ажиллаж байна. Хөтөлбөр хэрэгжүүлж буй үндсэн, гэрээт, цагийн багш нар бүгд доктор зэрэгтэй хууль зүйн салбарын тэргүүлэх мэргэжилтнүүд байна.
- Эрх зүйн магистрын хөтөлбөрт хичээл орох докторын зэрэгтэй багшийн тоо сүүлийн 5 жилд байнга өссөн байх бөгөөд докторын зэрэгтэй багш нар хичээл орох нь эрх

зүйн магистрын хөтөлбөрт суралцагчдын судалгааны ажил болон эрдэм шинжилгээний ажилд дэмжлэг туслалцаа үзүүлэх гол түлхүүр болдог.

- Шинжлэх ухааны сургууль нь 2019-2020 оны хичээлийн жилд нийт 17 багштай ажиллаж байгаа бөгөөд үүнээс үндсэн 9 багш, гэрээт 4 багш, цагийн 4 багштайгаар хичээл сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулж байна.
- Шинжлэх ухааны сургуулийн багшийн цагийн ачааллыг тогтоохдоо ИЗОУИС-ийн удирдах зөвлөлөөс гаргасан дараах дүрэм, журмуудыг удирдлага болгон ажиллаж байна. Тухайлбал:
 - ИЗОУИС-ийн багш нарын ажлын үр дүнг харгалзан олгох цалингийн журам /2017 оны 10 сарын 20-ны өдрийн, Удирдах зөвлөлийн 11 тоот тогтоолын хавсралт/
 - ИЗОУИС-ийн Багшийн албан тушаалын зэрэглэл олгох журам /2012 оны 03 сарын 26-ны өдрийн, Ректорын 1/237/
 - ИЗОУИС-ийн Магистрын сургалтын журам /2007 оны 11-р сарын 15-ны өдрийн, Ректорын 1/70 тоот тушаал /
 - ИЗОУИС-ийн Сургалтын журам /2015 оны 11 сарын 11-ний өдрийн, Ректорын А/187 тоот тушаал/
 - ИЗОУИС-ийн Багшийн албан тушаалын зэрэглэлийн шалгуур үзүүлэлтүүд /2009 оны 11-р сарын 24-ний өдрийн, Ректорын 1/84 тоот тушаал /
 - ИЗОУИС-ийн багшийн ажлын үнэлгээний журам /2017 оны 10-р сарын 20-ны өдрийн, Удирдах зөвлөлийн 06 тоот тогтоолын хавсралт/ зэрэг болно.
- ИЗОУИС-ийн үндсэн багш нартай сургуулийн захиргаа нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Их Засаг ОУИС-ийн Ректорын тушаалаар баталсан холбогдох дүрэм, журам, зааврыг үндэс болгон Хөдөлмөрийн гэрээг байгуулж, жилийн эцэст багш бүр өөрийн үнэлгээний тайлан бичиж, жилийн ажлаа сургуулийн захиргаандаа тайлагнадаг байна. Аттестатчиллын комиссыг Ректорын тушаалаар батална. Комиссын шийдвэрийг үндэслэн Ректорын тушаалаар, багшийн зэрэглэлийг ахиулах, бууруулах, цалингийн тодорхой хувиар шагнах, хасах, хөдөлмөрийн гэрээг сунгах, цуцлах зэрэг асуудлуудыг шийдвэрлэдэг нь баримт бичиг болон хурлын тэмдэглэл, Ректорын тушаалуудаар нотлогдож байна.
- Харин гэрээт болон цагийн багш нартай хөлсөөр ажиллах гэрээ байгуулсныг үндэслэн Ректорын тушаалаар хичээл орох эрх нь нээгдэнэ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/ Туршлага:

- Багшийн нөөцийн сонгон шалгаруулалтыг нээлттэй, ил тод зарлан зохион байгуулдаг.
- Багш нар нь тогтвор суурьшилтай ажилладаг. Дунджаар 7-12 жил ажилласан байна.
- Багшийг урамшуулах, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх тусгай журмууд үйлчилдэг. Сүүлийн 5 жилд ШУС-ийн багш нарын бүтээлээ хэвлүүлэх зардалд нь сургалтын төлбөрийн 3-5 хувийг олгож дэмжлэг

үзүүлсэн байна. Мөн багш нарын орон сууц барин, хүүгүй зээл, хөнгөлөлттэй үнээр багш нартаа өгсөн байна.

- Их Засаг ОУИС-ийн харьяа байгууллагуудаар /цэцэрлэг, лицей сургууль, их сургууль, Хүннү-Хөдөө арал жуулчны бааз, Тэрэлж-Бумбан Тур жуулчны бааз, Хүннү ресторан гэх мэт/ багш нар үйлчлүүлэхдээ 30-50 хувийн хөнгөлөлт эдэлдэг.
- Багш нарынхаа хөдөлмөрийг төр засгаар үнэлүүлэх, төрийн одон медалиар шагнуулахад анхаардаг нь багш нарын шагналын судалгаанаас харагдаж байна.

Зөвлөмж:

- Багшид үзүүлж буй нийгмийн халамж үйлчилгээний цар хүрээг тэлэх

6.2 Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- ШУС нь 2014 онд Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангах, ШУС-ийн профессор багш нарын ажлын байран дээрээ хөгжих, багшийн өөрөө өөрийгөө хөгжүүлэх зэрэг асуудлыг дэмжих үндсэн чиг үүрэг бүхий Багшийн хөгжлийн төвийг байгуулсан байна. Энэ төв нь орчин үеийн сургалт, судалгааны ажилд хэрэглэж буй бүхий л техник хэрэгслээр бүрэн хангагдсан. Өндөр хурдны интернет, хайлтын системтэй. Мини номын сан, цахим номын сан, өдөр тутмын сонин сэтгүүлтэй.
- ИЗОУИС нь багшийн хөгжлийн дэмжих хөтөлбөр, багш, ажилчдын хөгжлийг дэмжих журам боловсруулан мөрдөн ажилладаг байна. Тус хөтөлбөр нь ИЗОУИС-ийг 2030 он хүртэл хөгжүүлэх стратеги төлөвлөгөөтэй уялдаж өгсөн нь багш нарыг үе шаттайгаар хөгжих таатай нөхцөл бүрдүүлж өгсөн байна.
- Багш бүр өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөтэй. Түүнийхээ биелэлтийг жилийн эцэст тайлагнадаг.
- Багшийг эрдмийн зэрэг хамгаалах, дотоод гадаадын байгууллагуудтай хамтран ажиллаж хурал, сургалт зэрэгт явахад замын зардал, амьжиргааны мөнгө зэргээс гадна цалинтай чөлөө олгодог байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/ Туршлага:

- Их Засаг ОУИС нь багшийн хөгжлийн дэмжих хөтөлбөр, багш, ажилчдын хөгжлийг дэмжих журамтай. Түүнийг хэрэгжүүлэх багшийн хөгжлийн төвтэй.
- Багш нарынхаа судалгааны ажлын ур чадварыг ахиулахад онцгой анхааран ажиллаж жил бүр Багшийн хөгжил-21 зуун“ ЭШХ-ыг зохион байгуулж шагналт байранд шалгарсан багш нарыг өндрөөр урамшуулдаг байна.

Анхаарах асуудал:

- Багш нарын өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөний бодит байж /биелүүлж чадах/ чадах талд анхаарах

Зөвлөмж:

- ШУС нь багш нараа хамарсан олон төрлийн сургалт зохион байгуулах
- Бусад бүрэлдэхүүний сургуулийн багш нартаа лекц, семинар зохион байгуулах

6.3 Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Сүүлийн 5 жилд ШУС-ийн 12 багш ОУ-ын ЭШХ, сургалт семинарт хамрагдсан 13 багш бүтээл хэвлүүлэх санхүүгийн дэмжлэг, 3 багш докторын зэрэг хамгаалахдаа цалинтай чөлөө авсан байна.
- ШУС-ийн багш нар сүүлийн 5 жилд 56 нэр төрлийн ном, сурах бичиг, гарын авлага, илтгэл өгүүлэл бичиж хэвлүүлсэн байна
- Сүүлийн 5 жилд ШУС-ийн 3 багш докторын зэргээ амжилттай хамгаалсан байна.
- Сургуулиас болон бусад байгууллагуудаас зохион байгуулсан ОУЭШХ-д давхардсан тоогоор 14 багш оролцож илтгэлээ хэлэлцүүлсэн байгаа нь хурлын эмхэтгэлээр нотлогдож байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/ Туршлага:

- Сүүлийн 5 жилд ШУС-ийн 3 багш докторын зэргээ амжилттай хамгаалсан байна.
- Жилд 2-3 удаа ОУЭШХ-ыг зохион байгуулж хэвшсэн байна.

Анхаарах асуудал:

- Олон улсын нэр хүнд бүхий сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх багшийн тоог нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Судалгааны ажлын цар хүрээг улам нэмэгдүүлэх

6.4 Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- ИЗОУИС-ийн Удирдах Зөвлөлийн 2017 оны 10 сарын 20-ны өдрийн 06 тоот тогтоолын хавсралтаар ИЗОУИС-ийн багшийн ажлын үнэлгээний журмыг шинэчлэн тогтоосон бөгөөд ИЗОУИС-ийн профессор багшийн ажлын байрны тодорхойлтонд заасан чиг үүргийн хүрээнд гүйцэтгэх сургалт, эрдэм шинжилгээ, инновацийн болон мэргэжлийн бусад ажил үйлчилгээний чиглэлээр гүйцэтгэх ажлыг төлөвлөх,

гүйцэтгэлийг тооцох уг журмыг үйлчлэхээр зохицуулсан бөгөөд дээрх тогтоолыг ШУС мөрдөж ажиллаж байна.

- Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцон ажиллаж байна.
- ИЗОУИС-ийн Ректорын 2018 оны 5 сарын 2-ны өдрийн 63 тоот тушаалаар батлагдсан Багш нарыг аттестатчилах журамд заасны дагуу багш нарыг мэргэжил, сургалт, эрдэм шинжилгээ, заах арга зүйн чиглэлээр нь 2 жил тутамд аттестатчилал явуулдаг. Аттестатчиллын дүнгээс хамааран багшийн зэрэглэл ахих, буурах, хөдөлмөрийн гэрээг сунгах, дуусгавар болгох, цалингийн тодорхой хувиар урамшуулах эсэх асуудлыг Ректорын тушаалаар шийдвэрлэнэ. Тухайлбал, сүүлийн 2 удаагийн аттестатчиллаар 8 багш зэрэглэл ахиж, 3 багш зэрэглэл буурч, 1 багшийн хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгосон байна.
- Суралцагчдаас багш бүрээр сэтгэл ханамжийн судалгаа авч үр дүнг тооцож ажилладаг. Ерөнхийдөө багшдаа өгсөн суралцагчдын үнэлгээ дундаас дээш байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/ Туршлага:

- Багшийн өөрийн үнэлгээний механизмыг хэрэгжүүлсэн байна.

Анхаарах асуудал:

- Багшийн үйл ажиллагааны талаарх суралцагчдын өгсөн судалгааны бодитой байх тал дээр цаашдаа анхаарах

Зөвлөмж:

- Хамт олны үнэлгээг хэрэгжүүлэх

6-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1 Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- ИЗОУИС-ийн Ректорын тушаалаар батлагдсан 2014 оны 05 сарын 01 өдрийн 1/200 тоот “Сургалтын чанарын удирдлагын тогтолцооны бүдүүвчийг батлах тухай”, 2017 оны 10 сарын 25 өдрийн 1/45 тоот “ИЗОУИС-ийн чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх журам”, 2017 оны 10 сарын 09-ны өдрийн А/80 тоот ИЗОУИС-ийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам” 2019 оны 09 сарын 23-ны өдрийн А/80 тоот

“ИЗОУИС-ийн Чанарын баталгаажуулалтын албаны ажиллах дүрэм” зэргийг тус тус үндэслэн хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалт сайжруулалтыг Эрх зүйн магистрын хөтөлбөртөө хэрэгжүүлдэг.

- Чанарын үнэлгээнд баталгаажуулалт хийх зорилгоор суралцагчдын дунд сэтгэл ханамжийн мониторинг судалгааг авч, сургалтын хэрэгцээнд ашиглаж байна. Багш ажилчдын ажлын чанарын үнэлгээг сайжруулах зорилгоор ИЗОУИС-ийн удирдлагын зүгээс томилогдсон АГҮБ дотоод чанарын баталаажуулалтыг хэрэгжүүлэх зорилгоор хяналт тавин шинжилгээ үнэлэлт хийн ажиллаж байна.
- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлэх хүрээнд бүтцийн хувьд Хөтөлбөрийн хороо, дэд хороог байгуулж, хөтөлбөрийн удирдагч багш нарыг удирдлагаар ханган ажиллаж, хяналт тавин ажилладаг.
- Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний баг, Чанарын баталгаажуулалтын алба, Сургалтын нэгдсэн албанаас тухайн улирлын хугацаанд орж байгаа хичээлийн хөтөлбөрийн стандарт агуулга, түүний хэрэгжилтэнд хяналт тавьж үнэлэлт дүгнэлт өгч ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/ Туршлага:

- Батлагдсан хөтөлбөрийн дагуу хичээлийг орж дууссаны дараа хичээлд хамрагдсан суралцагчдаас үр дүнгийн талаарх үнэлэлт дүгнэлт хийлгэдэг.
- Төгсөгч, ажил олгогчдоос судалгаа авч үр дүнг нэгтгэн ажиллаж хэвшсэн байна.

Анхаарах асуудал:

- Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрт оролцогч, сонирхогч талуудын оролцоог улам тодорхой болгож, үр дүнг тооцож байх

Зөвлөмж:

- Социологийн судалгааны асуултын боловсруулалтыг сайжруулах

7.2 Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Илрэл нотолгоо:

- 2017 оноос оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааг эхний ээлжинд тус сургуульд суралцагч нараас ялгамжтай байдлаар 4 чиглэлээр авч эхэлсэн нь үр дүнтэй бодит хэрэгцээнд суурилсан судалгаа болж чадсан.
- 2018 оноос ажил олгогч байгууллагаас тодорхой чиглэлээр сэтгэл ханамжийн судалгаа авч, үнэлэлт дүгнэлт өгч ажиллаж байна.

- Жил бүр төгсөгчдөөс докторын сургалтанд төгсөгч нар хөнгөлөлттэй элсэн суралцаж байна. Энэ нь эрх зүйн мэргэжлээр төгсөгч магиструудын 15%-20%-ийг эзэлж байна.
- Сургуулийн дотоод хяналт шинжилгээ, үнэлгээг өргөтгөх, ур чадвараа хөгжүүлэн, сургалтын чанараа сайжруулах зорилгоор хөтөлбөрийн хороо, дэд хороодыг байгуулан ажиллаж байгаа нь хөтөлбөрийн шинэчлэл хийх орчин бүрдсэн ба сургуулийн бүтцэд Чанарын баталгаажуулалтын албыг бий болгосон нь хөтөлбөрийн үр дүн, хэрэгжилтэд дотооддоо өөрийн үнэлгээ хийх боломжтой болсон байна.
- Үйл ажиллагаандаа хяналт шалгалт хийх, хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж, багш нарын ажлын гүйцэтгэлийг үнэлэх баг /АГҮБ/ нь сар тутамд ажиллаж, үр дүнг нарийн тооцож сургуулийн удирдлагын багийн хуралд тайлагнадаг байна. Энэ нь хичээлийн жилийн турш тасралтгүй, жигд үйл ажиллагаатай байх, архив, бичиг хэргийн соёл, стандартыг хангуулахад ихээхэн ач холбогдолтой байдаг нь цуглуулсан нотлох баримтуудаас харагдаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/ Туршлага:

- Хичээлийн хөтөлбөрүүд сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилтод нийцэж байгаа байдалд дотоод үнэлгээ хийж хөтөлбөрүүдээ шинэчлэн сайжруулсан.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдөөс авсан судалгаануудаар тусгай сан бүрдүүлэх

Зөвлөмж:

- Судалгааны үр дүнгээр дорвитой ажил зохион байгуулах

7.3 Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- 2009 онд Английн нийслэл Лондон хотод В.I.D байгууллагаас Алтан категорын хаан титэм шагнал авсан байна.
- 2013 онд Франц улсын нийслэл Парис хотноо Дэлхийн чанарын баталгаажуулалтын дээд шагналыг ПЛАТИНУМ төрөлд хүртсэн байна.
- Их Британийн үндэсний Магадлан Итгэмжлэх Зөвлөл /ВАС/-өөр 2014 оны 10 дугаар сард Олон Улсын хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн юм. 2017 оны 11 дүгээр сард дахин магадлан итгэмжлэлд дээд боловсролын байгууллагын ангиллаар шалгагдан амжилттай дүн үзүүлсэн нь тус сургуулийн хувьд маш том амжилт юм.

- Испанийн CSIC (Consejo Superior de Investigaciones Cientificas) Судалгааны байгууллагаас дэлхийн 24000 их, дээд сургуулийг сургалтын үр дүнтэй, ил тод, нээлттэй бодлого, сургуулиудын нэр хүнд, мэдээллийн цар хүрээгээр эрэмбэлсэн байна. Энэхүү олон улсын боловсролын байгууллагуудын эрэмбэлэлтэд Монгол Улсаас 24 их дээд сургуулийг багтаасны 14-т ИЗОУИС эрэмбэлэгдсэн байна.
- ИЗОУИС нь Монгол Улсын TOP 5 сургуулийн нэг, MOX-ны “Оюутанд ээлтэй сургууль” шалгаруулалтанд 3 удаа тэргүүлсэн, үндэсний хэмжээнд санал асуулгаар шилдгүүдийг тодруулдаг ГРАНД ЭКСПО, BEST OF MONGOLIA–д 3 жил дараалан тэргүүлж Үндэсний хэмжээний шилдгийн шилдэг сургуулиар шалгарсан байна.
- Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд багш судлаач, оюутан суралцагч солилцох (1+1 хөтөлбөр), хамтарсан олон улсын эрдэм шинжилгээний хурал, эрдэм шинжилгээний хурал, уулзалт, семинар, судалгааны ажил, богино хугацааны сургалтууд, сургалт, арга зүйн материал, сурах бичиг хамтран боловсруулах, солилцох, оюутны мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор хамтарсан төслүүдийг хэрэгжүүлэх зэрэг хэлбэрээр ажилладаг.
- Сургууль Чанарын удирдлагын олон улсын стандарт Ази Номхон Далайн Бүс Нутгийн Чанарын Сүлжээний гишүүн сургууль болж, үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцож байна. Мөн Их Засаг ОУИС чанарын удирдлагын ISO9001:2015 стандартыг нэвтрүүлсэн зэрэг нь Олон Улсад хүлээн зөвшөөрөгдөх үндэс суурь тавигдсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/ Туршлага:

- Их Британийн үндэсний Магадлан Итгэмжлэх Зөвлөлөөр /ВАС/ 2014 оны 10 дугаар сард Олон Улсын хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн юм.
- 2017 оны 11 дүгээр сард Их Британийн Магадлан Итгэмжлэх Зөвлөлийн дахин магадлан итгэмжлэлд дээд боловсролын байгууллагын ангиллаар шалгагдан амжилттай дүн үзүүлсэн байна.

Анхаарах асуудал:

- Магиструуд нь дараагийн шатны боловсролын үйлчилгээг дурын гадаад улс оронд шууд үргэлжлүүлэн авах боломжийг судлах

7-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ

№	Шалгуур	Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Хангаагүй үнэлгээ өгсөн бол үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2			
2	Сургалтын үйл ажиллагаа	2			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2			
4	Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт	2			
5	Суралчагчид чиглэсэн үйл ажиллагаа	2			
6	Багшийн үйл ажиллагаа	2			
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	2			
	Дүгнэлт	Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлагад үндэслэн шинжээчийн баг Их Засаг ОУИС-ийн ШУС-ийн эрх зүйн магистрын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлагад нийцэж байгаа тул **“ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН”** гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Эрх зүйн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг Ж.Мөнхболд.....

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг Ш.Цогтоо.....

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг Ж.Ганболд.....

IV. ЯРИЛЦЛАГАД ОРОЛЦОГЧДЫН НЭРС

I. Багш, ажилтны төлөөлөл

№	Овог нэр	Байгууллага, албан тушаал	Заадаг хичээл	Утас	И-мэйл хаяг
1	Ж. Цэцэгмаа	Их Засаг ОУИС-ийн 1-р проректор	МТЭЗТ	99116486	tsetseg0409@yahoo.com
2	Г. Туяа	Сургалт, инноваци эрхэлсэн проректор	Хүний эрх	88007046	GTuya12gmail.com
3	Г.Наранбаатар	ШУС-ийн захирал	ЭХХША-ны онол практикийн асуудал	99998621	Naranbaatar_g@yahoo.com
4	Ю. Майцэнгэл	Хөтөлбөрийн удирдагч	ажилтан	88976622	Maitsengel0501@gmail.com
5	Д. Одгэрэл	Эрдэмтэн нарийн бичгийн дарга	Судалгааны арга зүй	89334445	Odgerel861@gmail.com
6	Ц. Хонгорзул	Сургалтын албаны мэргэжилтэн	ажилтан	99131124	Khongorzul0826@gmail.com
7	С. Нямцэцэг	Номын сангийн ажилтан	ажилтан	99804473	Suhbaatarnyamaa@gmail.com
8	Х.Лутчимэг	Чанарын баталгаажуулалтын албаны дарга	ажилтан	99076255	lutchimeg_ub@yahoo.com
9	П.Оюунзул	Сургалтын нэгдсэн албаны мэргэжилтэн	ажилтан	96389968	poyunzul1212@gmail.com
10	Г.Ууганболор	Багш	Харьцуулсан эрүүгийн эрх зүй	99132396	ubolor_g@yahoo.com
11	Л.Намнансүрэн	Багш	Үндсэн хуулийн онол практикийн асуудал	91909196	Namnaalv@gmail.com
12	Ч.Батхишиг	Санхүү бүртгэлийн алба, ахлах нягтлан бодогч	ажилтан	88117410	Ch.batkishig@yahoo.com
13	Н.Ган-Эрдэнэ	Лабораторын эрхлэгч	ажилтан	99041758	gandeneub@gmail.com
14	З.Оюун-Эрдэнэ	ГХА-ны мэргэжилтэн	ажилтан	99087958	oyukaiziu@gmail.com
15	Б.Одонтунгалаг	Хүний нөөцийн албаны мэргэжилтэн	ажилтан	88031103	odnoo1210@yahoo.com

II. Суралцагчийн төлөөлөл

№	Овог	Нэр	Сура лцаж буй курс	Ярилцлагад сонгосон шалтгаан	Утасны дугаар	Цахим хаяг
1	Сүрэнхорлоо	Ариунаа	2	Төгсөөд олон жил болоод магистрын хөтөлбөрт хамрагдсан	99858643	a99858643@gmail.com
2	Батсүх	Ариунболор	1	Төгсөөд олон жил болоод магистрын хөтөлбөрт хамрагдсан	99074727	Ariuka_ok@yahoo.com
3	Мөнхсахъяа	Баасансүрэн	2	Бакалавр төгсөөд шууд магистрын хөтөлбөрт хамрагдсан	88429115	baasansurenmon94@gmail.com
4	Цэдэндулам	Баттулга	2	Төгсөөд олон жил болоод магистрын хөтөлбөрт хамрагдсан	88009558	ts.battulga08@yahoo.com
5	Ганбаатар	Баярцэцэг	2	Дотуур байранд амьдардаг	99044911	bbayartsetseg65@gmail.com
6	Эрдэнэбат	Билэгсайхан	2	Бакалавр төгсөөд шууд магистрын хөтөлбөрт хамрагдсан	80242400	bilgee.bileg37@gmail.com
7	Түвшинбаяр	Буян-Арвижих	1	Хөдөө орон нутгаас суралцдаг	88249020	aaajii0902@gmail.com
8	Мөнхөө	Буянхишиг	2	Бакалавр төгсөөд шууд магистрын хөтөлбөрт хамрагдсан	99863523	Mglpro940@gmail.com
9	Сарантуяа	Бямбадаваа	2	Хөдөө орон нутгаас суралцдаг	95932478	byambadavaa980@gmail.com
10	Амарбаясгалан	Гантулга	2	Бакалавр төгсөөд шууд магистрын хөтөлбөрт хамрагдсан	98103010	agantulga16@gmail.com
11	Загиржав	Даваажав	1	Төгсөөд олон жил болоод магистрын хөтөлбөрт хамрагдсан	99118934	zdavaajav@yahoo.com
12	Отгонлхагвасүрэн	Ёндонжамц	1	Бакалавр төгсөөд шууд магистрын хөтөлбөрт хамрагдсан	90090828	vndko.4004@gmail.com

13	Цогбаяр	Жавзанпагма	1	Бакалавр төгсөөд шууд магистрын хөтөлбөрт хамрагдсан	99044003	Javzanpagmatsogb ayar7gmail.com
14	Чойжилсүрэн	Жаргалан	1	Бакалавр төгсөөд шууд магистрын хөтөлбөрт хамрагдсан	99100577	jrgln2008@gmail.com
15	Нэргүй	Золзаяа	2	Бакалавр төгсөөд шууд магистрын хөтөлбөрт хамрагдсан	99677189	nergui.zolzaya33@yahoo.com
16	Эрдэнэбаатар	Мандуул	1	Бакалавр төгсөөд шууд магистрын хөтөлбөрт хамрагдсан	96110134	Mnduul1919@gmail.com
17	Эрдэнэбаатар	Номин-Эрдэнэ	1	Төгсөөд олон жил болоод магистрын хөтөлбөрт хамрагдсан	86114850	Nominerdenee1@gmail.com
18	Норов	Оюунцэцэг	1	Төгсөөд олон жил болоод магистрын хөтөлбөрт хамрагдсан	99031154	oyuh9903@gmail.com
19	Бямбацогт	Өлзийцэрэн	2	Бакалавр төгсөөд шууд магистрын хөтөлбөрт хамрагдсан	99074727	Ulzii8248@gmail.com
20	Сайжийбамбуу	Өнөрцэцэг	2	Төгсөөд олон жил болоод магистрын хөтөлбөрт хамрагдсан	99148826	unurtsetseg@gmail.com
21	Баярсайхан	Пүрэвдавуу	2	Дотуур байранд амьдардаг	99333413	pvrewdawuu1028@gmail.com
22	Баярсайхан	Солонго	2	Бакалавр төгсөөд шууд магистрын хөтөлбөрт хамрагдсан	91000142	s_soko9695@yahoo.com
23	Намсрайжав	Сувд-Эрдэнэ	2	Бакалавр төгсөөд шууд магистрын хөтөлбөрт хамрагдсан	94999949	Suvdaa0899@gmail.com
24	Төгсжаргал	Тамир	1	Төгсөөд олон жил болоод магистрын хөтөлбөрт хамрагдсан	99098348	tamir3a@gmail.com
25	Баярмагнай	Түвшинжаргал	2	Хөдөө орон нутгаас суралцдаг	99407979	Pro_mn7979@yahoo.com
26	Нямаа	Ундрах	2	Дотуур байранд амьдардаг	99176204	Undrakh_N28@yahoo.com

27	Бямбажав	Ундрах	2	Бакалавр төгсөөд шууд магистрын хөтөлбөрт хамрагдсан	96666889	uugii3406@gmail.com
28	Даваадорж	Уянгоо	2	Бакалавр төгсөөд шууд магистрын хөтөлбөрт хамрагдсан	95056437	uyangoog@gmail.com
29	Мянган	Цэрэнжаргал	2	Дотуур байранд амьдардаг	99328095	tmyangan@gmail.com
30	Болдхуяг	Эрдэнэзаяа	2	Хөдөө орон нутгаас суралцдаг	99193305	zayaboldhuyag@gmail.com
31	Батбаяр	Энхбат	2	Бакалавр төгсөөд шууд магистрын хөтөлбөрт хамрагдсан	90424225	Enhbat333@gmail.com

III. Ажил олгогчдын төлөөлөл

№	Овог нэр	Байгууллага, албан тушаал	Утас	Имэйл хаяг
1.	Р.Онончимэг	Монголын Нотариатчдын Танхимын Ерөнхийлөгч	99095860	Oono_mn@yahoo.com
2.	Ч.Жадамба	Нийслэлийн Өмгөөлөгчдийн Зөвлөлийн дарга	91118225	
3.	Ш.Жалборос	Монголын Хуульчдын Холбооны Тамгын газрын дэд дарга	99994004	Jalbars82@gmail.com
4.	Ш.Сүхбат	Нийслэлийн Прокурорын газрын тамгын дарга	99114249	
5.	Д.Одхүү	Баянзүрх, Сүхбаатар Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын дарга	99092345	
6.	Б.Бээжин	Баянгол, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын дарга	99072851	Beejin_519@yahoo.com
7.	Н.Ганбаяр	Шүүхийн Шинжилгээний Үндэсний Хүрээлэнгийн дэд дарга	91998787	ganbayar0404@yahoo.com
8.	Б.Нандин-Эрдэнэ	“Дүнжингарав” ХХК-ны гүйцэтгэх захирал	91112814	Nandinerdene1@gmail.com

9.	Ч.Баянжаргал	МНТ-ийн УЗ-ийн гишүүн нотариатч	99110557	
10	Б.Гантөмөр	MGL фирмийн захирал	88118737	Gantumur.bu@gmail.com
11	О.Март	“Понгури” ХХК-ний захирал	99025256	
12	Ч.Жамьянсүрэн	“Монгол банк”-ны Дархан дахь салбарын захирал	99095860	
13	Б.Отгонбаяр	“М-ОЙЛ” ХХК-ны захирал	99992221	Otgoodavid@gmail.com
14	Ц. Хонгорзул	Дархан Уул аймгийн 445-р хорих ангийн дэд дарга	99029403	Darkhan_shda@cd.gov.mn
15	Э. Чулуунтогтох	“Энвэнгко” ХХК-ны захирал	98119008	Chukka.cdm@gmail.com
16	Ц.Сувдаа	Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын дарга	99492009	ulziisuvdaa@yahoo.com

IV. Төгсөгчдийн төлөөлөл

№	Овог, нэр	Төгссөн он	Ажил	Утасны дугаар	И-мэйл
1	Э.Түмэнбаяр	2013	Өмгөөлөгч, багш	88060598	tumenbayar.ius@gmail.com
2	Б.Сарнай	2015	Өмгөөлөгч	99112560	Sarnaikhan.sr@gmail.com
3	Б.Ариунзаяа	2015	Үндэсний аудитын газрын хуулийн зөвлөх	86648989	anzemgl@gmail.com
4	Д.Отгонтуяа	2015	Улаанбаатар бүүк компани хуулийн зөвлөх	99999739	Oogii0617@yahoo.com
5	Г.Онон	2015	Өмгөөллийн Илч товчоо ХХН-д хуулийн мэргэжилтэн	99712008	G.Onon008@gmail.com
6	Н.Ариунсанаа	2015	Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газарт	99085183	ariunsanaa2013@gmail.com

			гаалийн улсын байцаагч		
7	Х.Одбаяр	2017	Замын цагдаагийн хэлтсийн ахлах зохицуулагч	80680000	kh_od_bayar@yahoo.com
8	Э.Майбаяр	2017	ИЗОУИС багш	98004050	maibayarerdene@gmail.com
9	Д.Оюунчимэг	2017	ЦЕГ-ын НХЖХОНАБХ албаны ахлах байцаагч	99086315	oyuoyunaa0308@gmail.com
10	Б.Алтантуяа	2017	БЗД ХХҮХэлтэс	99838508	Haliun_1978@gmail.com
11	Д.Мягмарсүрэн	2017	Дотоодын цэрэг 805-р анги	99992189	myagmarsuren Dorjpurev@yahoo.com
12	А.Номин-Эрдэнэ	2017	БЗД Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн туслах	99020570	Anominerdene35@gmail.com
13	Б.Энхзаяа	2017	Хуулийн зөвлөх	99909870	mebz_0201@yahoo.com
14	Ш.Бямбадорж	2017	Өмгөөлөгч	88089629	Shagdar.Byambadorj@gmail.com
15	Г.Ганбаяр	2015	Өмгөөлөгч	91687578	ganbayar1991@gmail.com
16	Т.Маргад-Эрдэнэ	2018	СХД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн туслах	88007325	margaamargaa883@gmail.com
17	Б.Булгантамир	2018	Өмгөөлөгч	88053408	Bulgantamir0229@gmail.com
18	Б.Нямбаяр	2019	Хуулийн зөвлөх	99107534	nyambaa23@gmail.com
19	Э.Батбилэг	2019	БГД-ийн ЗД-ын орлогч	99080507	enkhboldbatbileg0510@gmail.com
20	Б.Даваа	2019	Монголын сэтгүүлчдийн холбоо	99111880	davaa1880@gmail.com
21	С.Бямбадэлгэр	2019	МНВ телевиз дохионы хэлмэрч	88112497	so_bdelger@yahoo.com

22	Б.Батцэцэг	2019	Дотоод хэргийн сургуулийн онцгой байдлын сургуулийн лаборант	89152676	tseegiihdt@gmail.com
23	Х.Тогоохүү	2019	Kingsway ХХК гүйцэтгэх захирал	80901555	a.aksana@yahoo.com
24	Н.Булганаа	2019	ИЗОУИС багш	99908509	Bulgaab0629@gmail.com
25	Ш.Эрдэнэжаргал	2019	Хэнтий аймаг ИТХ-ын орон нутгийн хурал хурал хариуцсан ажилтан	99785453	Sh.erdenejargal@gmail.com
26	Б.Туул	2019	Үндэсний хөрөнгө оруулалтын банк - Гүйцэтгэх захирлын ажлын албаны мэргэжилтэн	99019638	tuul411@gmail.com
27	Б.Батцэцэг	2019	Анолт ХХК-д хуулийн зөвлөх	96977888	bbattsetseg5@gmail.com
28	Н.Нансалмаа	2019	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийн хуулийн зөвлөх	8815434	Az5@gmail.com
29	Б.Бадмаараг	2019	Шунхлай энержи ХХК-д хуулийн зөвлөх	99960000	bbbadmaarag@gmail.com
30	О.Нармандах	2019	БЗД ЦГ-ын 2-р хэлтсийн Хэрэг бүртгэх тасгийн ахлах мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч	99020507	Namu.nakamura@gmail.com

V. МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭР

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо).....[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

VI. МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ КОМИССЫН ШИЙДВЭР

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо).....[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/